

МОНГОЛ УЛСАД ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ

Карин Шелциг, Кирсти Ньюман

ДУГААР 28

2020 оны 11 дүгээр сар

АХБ-НЫ ЗҮҮН АЗИЙН ГАЗРААС
ЭРХЛЭН ГНВАРГАДАГ ТЕХНИКИЙН
ЦУВРАЛ ТАЙЛАН

АХБ-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг техникийн
цуврал тайлан

Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь

Карин Шелциг, Кирсти Ньюман

Дугаар 28 | 2020 оны 11 дүгээр сар

Карин Шелциг нь АХБ-ны Зүүн Азийг хариуцсан газрын Нийгмийн салбарын хэлтсийн Нийгмийн салбарын тэргүүлэх мэргэжилтэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улс дахь Суурин төлөөлөгчийн газарт томилогдон ажиллаж байна.

Кирсти Ньюман нь Тогтвортой хөгжил ба уур амьсгалын өөрчлөлтийн газрын Боловсролын салбарын багийн Боловсролын ахлах мэргэжилтэн бөгөөд Их Британийн Боловсролын комисст түр хугацаагаар томилогдон ажиллаж байна.



Creative Commons Attribution 3.0 IGO лиценз (CC BY 3.0 IGO)

Азийн Хөгжлийн Банк. 2020 он
АХБ-ны өргөн чөлөө 6, Мандалуён хот, Метро Манила 1550, Филиппин улс
Утас +63 2 8632 4444; Факс +63 2 8636 2444
www.adb.org

Зарим эрх хуулиар хамгаалагдсан. 2020 онд ФилиппинУлсад хэвлэв.

Хэвлэлийн дугаар. WPS210238-3
DOI: <http://dx.doi.org/10.22617/WPS210238-3>

Энэхүү хэвлэлд илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчдынх бөгөөд Азийн Хөгжлийн Банк (АХБ), түүний Захирлуудын Зөвлөл болон тэдний төлөөлж буй улс орнуудын засгийн газрын үзэл баримтлал, бодлогыг төлөөлөхгүй болно.

АХБ нь энэхүү хэвлэлд ашигласан тоо баримт, мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулахгүй бөгөөд тэдгээрийг ашигласны улмаас гарах аливаа үр дагаварт ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тодорхой компани эсвэл бүтээгдэхүүний тухай дурдсан нь дурдагдаагүй бусад ижил төрлийн компани эсвэл бүтээгдэхүүнээс тэдгээрийг илүүд үзэж сурталчлах буюу санал болгох утга агуулаагүй болно.

Аливаа нэг улс орон эсвэл газар зүйн бүсийг энэхүү хэвлэлд дурдсан буюу иш татсан, эсвэл “улс” гэсэн нэршлийг ашигласнаар АХБ нь тухайн улс орон эсвэл бүс нутгийн хууль эрх зүйн болон бусад нөхцөл байдлын тухайд ямар нэгэн дүгнэлт, байр суурь илэрхийлэхгүй болно.

Энэхүү бүтээлийг Creative Commons Attribution 3.0 IGO лицензийн дагуу (CC BY 3.0 IGO) <https://creativecommons.org/licenses/by/3.0/igo/> хүрээнд хийсэн болно. Энэхүү хэвлэлийн агуулгыг ашигласнаар та энэ лицензийн нөхцөлийг мөрдөх үүргийг хүлээн зөвшөөрнө. Эх сурвалжийг тогтоох, орчуулах, өөрчлөлт хийх болон зөвшөөрөл авах тохиолдолд <https://www.adb.org/terms-use#openaccess> холбоосоор орж заалт, нөхцөлүүдтэй танилцана уу.

Энэхүү CC лиценз нь тус хэвлэлд дурдагдсан АХБ-ны зохиогчийн эрхгүй материалуудад үл хамаарна. Хэрэв тухайн материал нь өөр эх сурвалжтай холбоотой бол түүнийг дахин хэвлэх, хуулбарлах зөвшөөрлийг тухайн эх сурвалж бүхий зохиогчийн эрхийн эзэмшигч эсвэл хэвлэгчид хандан авна уу. Тухайн материалыг ашигласны улмаас гарах аливаа гомдол шаардлагыг АХБ хариуцахгүй.

Агуулгын талаар асуух зүйл эсвэл санал байгаа тохиолдолд, эсвэл эдгээр нөхцөлөөс бусад зорилгоор ашиглахын тулд зохиогчийн эрхийн зөвшөөрөл авахыг хүсвэл, эсвэл АХБ-ны логог ашиглах зөвшөөрөл хүсэх тохиолдолд pubsmarketing@adb.org гэсэн хаягаар холбогдоно уу.

АХБ-ны хэвлэлийн залруулгыг дараах холбоосоор үзнэ үү: <http://www.adb.org/publications/corrigenda>.

Тайлбар:
Тус хэвлэлд хэрэглэсэн “\$” тэмдэгт нь америк долларыг илэрхийлнэ.

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг техникийн цуврал тайлан нь АХБ-ын Зүүн Азийг хариуцсан ажилтнууд, зөвлөхүүд, салбар салбарын мэргэжилтнүүдийн гүйцэтгэсэн ба гүйцэтгэж буй сүүлийн үеийн судалгааны ажил болон бодлогын судалгаануудын талаар ярилцлага өрнүүлэх, санал шүүмж хэлэлцүүлэх хэрэгсэл юм. Эдгээр цувралаар эдийн засаг болон хөгжлийн үндсэн бэрхшээлүүдээс гадна төсөл/хөтөлбөрийн эдийн засгийн дүн шинжилгээ, бодлогын сорилтуудтай холбоотой үзэл баримтлал, дүн шинжилгээ эсвэл арга зүйн асуудлууд, статистик мэдээлэл ба хэмжилтүүдийг авч үздэг. Цуврал нь Азийн улс орнуудын хөгжил болон бодлогын сорилтуудын талаарх мэдлэг, мэдээллийг эрчимжүүлэх; АХБ-ны улс орнуудад хэрэгжүүлдэг түншлэлийн стратегиуд, дэд бүсүүд болон улс орнууд дахь үйл ажиллагааны дүн шинжилгээний нарийвчлал ба чанарыг бэхжүүлэх; хөгжлийн үр дүнтэй байдалд хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд ба статистикийн мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулахыг зорьдог.

АХБ-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг техникийн цуврал тайлан нь шуурхай түгээгддэг албан бус хэвлэл бөгөөд эдгээрийн нэрийг мэргэжлийн сэтгүүлүүд дээр эсвэл номын бүлэг байдлаар хэвлэн нийтлэхдээ өөрчлөн хэрэглэж болно. Цувралыг Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг.

ГАРЧИГ

ХҮСНЭГТ, ГРАФИК, ШИГТГЭЭ	iv
ӨМНӨХ ҮГ БА ТАЛАРХАЛ	vi
ТОВЧИЛСОН ҮГС	viii
ХУРААНГУЙ	ix
1. УДИРТГАЛ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ЯДУУРАЛ БА БОЛОВСРОЛ МОНГОЛ УЛСАД	1
1.1 Хөгжлийн бэрхшээл, ядуурал, эмзэг байдал Монгол Улсад	2
1.2 Боловсролын хүртэмж: Тоон мэдээллийн өнөөгийн дүр зураг	4
1.3 Судалгааны арга зүйн талаарх товч мэдээлэл	8
2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ БА СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТЫН ШАЛТГААНУУД	12
2.1 Хөгжлийн бэрхшээлийн төрлүүдийг тодорхойлох нь	12
2.2 Боловсролын хүртээмж	12
3. ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ, БОДЛОГЫН ХҮРЭЭ МОНГОЛ УЛСАД	16
3.1 Үндэсний түвшний бодлогууд	16
3.2 Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас баталсан зарим журам, бодлогын баримт бичиг	18
4. МОНГОЛ УЛС ДАХЬ ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ИНДИКАТОРУУДЫГ БОЛОВСРУУЛАХ НЬ	19
4.1 Тэгш хамруулсан соёл	21
4.2 Тэгш хамруулсан бодлого	26
4.3 Тэгш хамруулсан практик үйл ажиллагаа	28
4.4 Тэгш хамруулсан материаллаг орчин	30
5. ДҮГНЭЛТ БА МОНГОЛ УЛСАД ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖҮҮД	37
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	46

ХҮСНЭГТ, ГРАФИК, ШИГТГЭЭ

ХҮСНЭГТ

1:	Улаанбаатар хот дахь тусгай сургуулиудад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2017–2018	7
2	Вашингтон бүлгийн үйлдлийн чадварын ангилал	9
3	Судалгаанд хамрагдсан өрх болон хүүхдийн тоо	10
4	Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 6–17 настай хүүхдүүдийн сургуульд хамрагдалт	14
5	Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 2–5 настай хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	15
6	Тэгш хамруулсан соёлын оноо	21
7	Тэгш хамруулсан бодлогын оноо	26
8	Тэгш хамруулсан практик үйл ажиллагааны оноо	28
9	Ажиглалтын хяналтын хуудсаар хийсэн асуулга судалгааны үр дүн	30
10	Тэгш хамруулах боловсролын төлөөх талуудын хамтын ажиллагаа	31
11	Засгийн газар болон хөгжлийн түншүүдэд хандсан зөвлөмжийн матриц	40

ГРАФИК

1	Цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2012–2018	5
2	Ердийн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2012–2018	6
3	Сургуулийн гадна буй хүүхдийн тоо, 2014–2018	8
4	Хөгжлийн бэрхшээлийн зэрэг	12
5	Сургууль дээрх тэгш хамруулсан соёл	23
6	Цэцэрлэг дээрх тэгш хамруулсан соёл	24
7	Аюулгүй байдлын талаарх эцэг эхчүүдийн үзэл бодол	25
8	Тэгш хамруулсан бодлого	27
9	Тэгш хамруулсан практик үйл ажиллагаа	29
10	Сургууль, цэцэрлэгийн гадаад орчин дахь саад бэрхшээлүүд	32
11	Дотоод орчинд тулгардаг саад бэрхшээлүүд	34
12	Сургууль дээрх материаллаг орчны хүртээмжтэй байдал	35
13	Сургууль, цэцэрлэгийн орчны хүртээмжтэй байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, эцэг эхчүүдийн мэдээлснээр	36

14	Дотоод, гадаад орчны аюулгүй байдлын талаарх эцэг эхчүүдийн үзэл бодол	36
15	Анги танхимын хүртээмжтэй байдлын талаарх багш нарын үзэл бодол	37

ШИГТГЭЭ

1	Сургууль дээрх дэмжлэг хангалтгүй	16
2	Багш нар таны хүүхэдтэй хэрхэн ажилладаг вэ?	26
3	Тусгай хэрэгцээнд үзүүлэх сургууль дээрх дэмжлэг	35

ӨМНӨХ ҮГ БА ТАЛАРХАЛ

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь ядууралтай холбоотой шийдвэрлэж амжаагүй асуудлууд болон тэгш бус байдлыг бууруулах талаарх 2030 он хүртэлх стратегийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн иргэдийн нийгэм дэх тэгш хамралт болон хүний хөгжлийг эрчимжүүлэхийг зорьж байна. 2030 он хүртэлх стратегид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмзэг бүлэгт хамруулан үзсэн билээ. АХБ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгох” тухай Инчёны стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд Тогтвортой хөгжлийн зорилгууд, олон улсын болон үндэсний хэмжээний хүчин чармайлтуудыг дэмжин ажиллаж байна. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд эдийн засаг, боловсролын талаарх боломжуудыг сайжруулах, төрийн үйлчилгээг эрчимжүүлэх явдлыг баталгаажуулахын тулд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг тэгш хамруулан авч үзэхэд чиглэсэн 25 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүхий хөгжлийн анхны бие даасан төслийг АХБ-аас 2017 оны 11 дүгээр сард баталсан билээ.^a

2018 оны 7 дугаар сард АХБ нь Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтад оролцож, Өөрчлөлтийн төлөөх Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтын тунхаг бичигт гарын үсэг зурж, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг тэгш хамруулсан хөгжлийг дэмжих чиглэлээр хэд хэдэн үүрэг амлалт авсан билээ. Тэгш хамруулах боловсролыг дэмжих талаар авсан тодорхой үүрэг амлалтууд нь (i) сургуулийн гадна буй хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд зэрэг нийгмийн хамгийн гадуурхагдсан бүлгийн хүүхдүүдийг тэгш хамруулахад илүү үр дүнтэй байдлаар дэмжлэг үзүүлэхэд дутагдаж буй талбар болон боломжуудыг илрүүлэн тодорхойлохын тулд боловсролын асуудлуудыг цогцоор хянан үзэх; (ii) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан хэрэглэхэд дөхөм материалууд болон сургалтын аргуудын чанар, сонголт, хамрах хүрээг өргөжүүлэхийн тулд шинэ нээлт, санаачилгуудыг дэмжих болон түгээмэл загвараар дамжуулан тэдний хувьд материаллаг орчныг илүү хүртээмжтэй болгох явдал байлаа.

Албан хэрэгцээний энэхүү баримт бичиг нь Монгол Улсын сонгогдсон орон нутагт амьдардаг үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд нь тулгарч буй саад бэрхшээлүүдийг судлан үнэлэх зорилгоор АХБ-ны захиалгаар Улаанбаатар хот дахь Хараат бус судалгааны хүрээлэн (ХБСХ)-ийн шинжээчдийн багаас 2019 онд хийсэн судалгаан дээр суурилсан билээ. Жүгдэрийн Мөнхбадараар ахлуулсан ХБСХ-ийн шинжээчдийн багт Дандийн Одгэрэл, Шагдарын Ариунболд, Чүлтэмсүрэнгийн Тамир, Базарсадын Мягмарсайхан, Доржнямбуугийн Бямбасүрэн, Дулмаагийн Лхагвацэрэн, Ганзоригийн Жаргалмаа, Хатанбаатарын Баярцэцэг, Алтансүхийн Очбадрал нар ажилласан.

Зохиогчдын зүгээс АХБ-ны техникийн туслалцааны 9216-МОН: *Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын хүртээмж, чанарыг тогтвортой байлгах нь* төслийн хүрээнд энэхүү судалгааг хийх санхүүжилтээр хангасан Ядуурлыг бууруулах Японы сан; судалгааны загвар, арга зүйг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн АХБ-ны зөвлөх бөгөөд Казакстаны Назарбаевын Их сургуулийн Тэгш хамруулах боловсролын мэргэжилтэн Сулуучино Патерт гүн талархал илэрхийлж байна. Энэхүү баримт бичигт тэрчлэн (2020

^a АХБ. 2017. Монгол Улс: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулах болон тэдэнд үйлчилгээ үзүүлэх явдлыг баталгаажуулах нь. Манила

оны 7 дугаар сард батлагдсан) Тэгш хамруулах боловсролыг дэмжих чиглэлээр Монгол Улсад үзүүлэх буцалтгүй тусламжийн төслийн баримт бичгийг боловсруулах үед АХБ-ны мэргэжилтэн, зөвлөхүүдийн бэлтгэсэн дүн шинжилгээний материалууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх зэрэг Монгол Улсын тэгш хамруулах боловсролд оролцогч бүхий л талуудтай хийсэн хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн асуудлуудыг тусгасан.

АХБ-ны удирдлага болон мэргэжилтнүүдийн зүгээс баримт бичгийн төслийг танилцуулах семинарын үеэр өгсөн саналууд болон Хүүхэд бүрийн төлөөх түншлэлийн хөгжлийн бэрхшээл-тэгш хамруулалтын мэргэжилтэн Жоанна Рожерс, Оксфордын бодлогын менежмент зөвлөх компанийн зүгээс өгсөн санал, зөвлөмжүүд нь энэхүү баримт бичгийг бэлтгэхэд чухал хувь нэмэр болсон билээ. Франческа Симасиогийн ерөнхий удирдлагын дор Моница Гамбоа (хянан тохиолдуулагч), КодМэнтра (эх бэлтгэгч), Коразон Десуасидо (хянан уншигч) нар хэвлэлтэд бэлтгэх ажлыг хариуцан ажиллалаа.

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ГХТ	ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөө
ХБСХ	Хараат бус судалгааны хүрээлэн
НТБТ	Насан туршийн боловсролын төв
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
ОУТС	Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалалын Яам
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
НТБҮТ	Насан туршийн боловсролын үндэсний төв
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТМБС	техник, мэргэжлийн боловсрол, сургалт
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

ХУРААНГУЙ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцахуйн хямралаас үүдэн ихээхэн хохирол амсаж байна. Тэд хэдийгээр нийт хүүхдийн ердөө 1.5–5%-ийг эзлэх ч дэлхийн хэмжээнд сургуулийн гадна буй хүүхдүүдийн талаас илүү хувийг бүрдүүлж байна. Хүүхэд бүр чанартай боловсрол эзэмших эрхийг хангах үүрэг амлалтаас урамшин тэгш хамруулах боловсролын төлөөх дэлхий дахины өсөн нэмэгдэж буй хүсэл эрмэлзэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа суралцаж, зохистой бөгөөд өндөр чанартай боловсрол эзэмших боломжтой боловсролын тогтолцоог хөхиүлэн дэмжиж байна. Тэгш хамруулах боловсролыг дэмжсэн дэлхий дахины энэхүү үүрэг амлалт нь тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсролыг баталгаажуулах болон бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих тухай Тогтвортой хөгжлийн зорилго 4-т тусгагдсан билээ. Тус баримт бичигт Монгол Улсын ердийн сургуулийн тогтолцооны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэгш хамруулсан боловсролыг олгож байгаа байдалд 2019 онд 5000 гаруй өрхийг хамруулан хийсэн судалгаа; багш нар, сургуулийн удирдах ажилтнууд, боловсролын яамны холбогдох хүмүүс, нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлага; болон дөрвөн аймаг, нийслэлийн нэг дүүргийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцсан байдал дээр суурилан шинжиллээ. Монгол Улс нь олон улсын түвшний шилдэг туршлагатай нийцүүлэн тэгш хамруулах боловсролын талаар хууль эрх зүй, бодлогын хүчирхэг орчныг бий болгосон боловч хэрэгжилт болон чадавхын хувьд хангалтгүй байна. Эдгээр асуудлыг тэгш хамруулах боловсролын дараах дөрвөн үзүүлэлтийн хүрээнд авч үзлээ: тэгш хамруулсан соёл, тэгш хамруулсан бодлого, тэгш хамруулсан практик үйл ажиллагаа, мөн тэгш хамруулсан материаллаг орчин. Дүгнэлт хэсэгт засгийн газар болон боловсролын салбар дахь хөгжлийн түншүүдэд зориулсан зөвлөмжүүдийг тусгалаа.

1. УДИРТГАЛ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ЯДУУРАЛ БА БОЛОВСРОЛ МОНГОЛ УЛСАД

1. **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ихээхэн хохирол учруулж буй суралцахуйн хямрал дэлхий нийтэд тулгараад байна.** Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд томоохон ахиц дэвшил гарсан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ихэвчлэн боловсролын үйлчилгээнд хамгийн сүүлд хамрагдах бүлэг болон үлдэж байна. Дэлхий нийтэд сургуулийн гадна буй 263 сая хүүхдийн талаас илүү хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгаа ч¹ тэд нийт хүүхдийн ердөө 1.5–5%-ийг эзэлдэг билээ.² Цаашилбал, сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцахуйн хувьд бусад хүүхдээс нэлээд хоцорч байна.³ Хүртээмж болон суралцахуйн энэхүү зөрүүтэй байдал нь олон шалтгаанаас үүдэлтэй. Үүнд:

- (i) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн чанартай боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг хаасан ялгаварлан гадуурхсан бодлого;
- (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахад нь саад учруулах, сургуульд явах урам зоригийг нь мохооход хүргэж болох ялгаварлан гадуурхалт ба дээрэлхэх явдал;
- (iii) багш нарын мэдлэггүй болон/эсвэл чадваргүй байдал;
- (iv) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн авьяас, чадварыг доогуур үнэлэх эсвэл тэднийг сургуульд хамрагдахыг эсэргүүцсэн сөрөг үзэл хандлага.⁴

2. Тэгш хамруулах боловсролын төлөөх дэлхий дахинд өрнөж буй хүсэл эрмэлзэл нь, энэхүү нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх болон хүүхэд бүрийн чанартай боловсрол эзэмших эрхийг хангах үүрэг амлалтаар тэтгэгдэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ мөр зэрэгцэн суралцах замаар зохистой бөгөөд өндөр чанартай боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх тогтолцоог дэмжиж байгаа билээ. Зарим хүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд суралцуулах тохиолдолд тэд тусгай мэргэжлийн багш хичээл заах сургалтад хамрагдахгүй эсвэл нэг ангид хамтдаа суралцаж буй бусад хүүхдийн суралцахуйд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үздэг. Гэвч сайтар зохион байгуулалт бүхий тэгш хамруулах боловсролын үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдэнтэй хамтдаа суралцаж буй бусад хүүхдүүдийн аль алиных хувьд ашиг тустай байдаг гэдгийг баталсан баримт нотолгоо нэмэгдсээр байна (Кулбир, Алгаиб нар 2019).

Тэгш хамруулах боловсрол нь хувь хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн нэмэлт дэмжлэг үзүүлэх замаар бүх хүүхдийг хамтдаа суралцах боломжтой болгодог.

3. **Тэгш хамруулах боловсролыг тодорхойлох нь.** Тус баримт бичигт бид тэгш хамруулах боловсролыг тодорхойлохдоо бүх хүүхдийг хамтдаа суралцахын зэрэгцээ өөр

¹ Боловсролын комисс. 2017. *Суралцагч үеийнхэн*. Нью Йорк: Боловсролын комисс.

² Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Банк. 2011. *Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан*. Малта.

³ Мэйл, С., К. Водон нар. 2017. *Үл хамруулалтын өртөг: Хөгжлийн бэрхшээл ба боловсрол. Суралцахуйн амжилт болон бичиг үсэг тайлагдалт дахь хөгжлийн бэрхшээлээс үүдсэн зөрүүтэй байдал*. Вашингтон: Боловсролын төлөөх дэлхийн түншлэл, Дэлхийн Банк.

⁴ Кулбир Сингх, Р., О. Абу Алгаиб нар. 2019. *Суралцагч нэг бүр үнэ цэнэтэй: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгарч буй суралцахуйн хямралыг дэлгэрүүлэн судлах нь*. Вашингтон: Дэлхийн Банкны Бүлэг.

өөрсдийн онцлог хэрэгцээнд тохирсон нэмэлт дэмжлэг авах өргөн утгаар нь авч үзлээ.⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн Ерөнхий зөвлөмж 4-ийн дагуу⁶ улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийг сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсрол; мэргэжлийн сургалт, насан туршдаа суралцахуй; хичээлээс гадуурх болон нийтийг хамарсан үйл ажиллагаа зэрэг боловсролын бүхий л түвшинд тэгш хамруулах тогтолцоогоор дамжуулан бодит биелэл болгох явдлыг баталгаажуулах үүрэгтэй. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүхий л суралцагчдыг ялгаварлан гадуурхалгүй, бусадтай адил тэгш боломжийн үндсэн дээр авч үзэх хэрэгтэй. Ерөнхий зөвлөмж 4-ийн арав дахь цогцолборт тодорхойлсноор тэгш хамруулах боловсролыг дараах байдлаар ойлгох хэрэгтэй:

- (i) Бүх суралцагчийн хувьд хүний үндсэн эрх. Тодруулбал, боловсрол бол хүүхдийн хувьд тухайн хувь суралцагчийн эдлэх эрх бөгөөд эцэг эх эсвэл асран хамгаалагчийн эрх биш. Иймээс эцэг эхийн үүрэг хариуцлага нь хүүхдийн эрхийг хангахад чиглэгдэнэ;
- (ii) Бүх суралцагчийн сайн сайхан байдлыг эрхэмлэж, тэдний төрөлхийн эрхэм чанар, бие даасан байдлыг хүндэтгэж, нийгмийн амьдралд үр дүнтэй оролцох, хувь нэмрээ оруулах тухайн хүний чадвар чадамж болон хувь хүний зүгээс тавих шаардлагыг хүлээн зөвшөөрөх зарчим;
- (iii) Хүний бусад эрхээ эдлэх арга зам. Энэ бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд өөрийгөө ядуурлаас гаргах, орон нутгийнхаа амьдралд бүрэн дүүрэн оролцох арга замыг эрж олох болон мөлжлөгөөс хамгаалагдах арга зам билээ. Энэ нь тэрчлэн тэгш хамруулсан нийгмийг бий болгох үндсэн арга зам болно;
- (iii) Сурч боловсрох эрхээ эдлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн тасралтгүй бөгөөд идэвхтэй үүрэг амлалт бүхий үйл явцын төдийгүй бүх суралцагчийг үр дүнтэй байдлаар тэгш хамруулан сургах чиглэлээр ердийн сургуулиудын хэвшмэл соёл, бодлого болон практик үйл ажиллагааг өөрчилснөөр хүрэх үр дүн.

4. Боловсролын нэгдмэл тогтолцооны зорилго нь багш, суралцагч хоёул олон талт ялгаатай шинж байдлаас үүдэх төрөл бүрийн сорилт бэрхшээл болон ашиг тусыг талархан хүлээн авч, хөхиүлэн дэмждэг суралцахуйн орчныг бүрдүүлэх явдал билээ. Тэгш хамруулах боловсрол нь үр бүтээлтэй суралцах орчныг бүрдүүлэн суралцагч нэг бүрийн өвөрмөц хэрэгцээг хангаж, хүн бүрд амжилтад хүрэх боломж олгодог. Тэгш хамруулах боловсролын төлөөх дэлхий дахины үүрэг амлалт нь тэрчлэн тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсролыг баталгаажуулах болон насан туршдаа суралцах боломжийг дэмжих талаарх Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) 4-т тусгагдсан билээ.

1.1 Хөгжлийн бэрхшээл, ядуурал, эмзэг байдал Монгол Улсад

5. **Хөгжлийн бэрхшээлийн тархалтыг тооцоолох нь.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллыг дэмжих тухай Монгол Улсын үндэсний хөтөлбөрт тусгагдсанаар 2017 оны байдлаар тус улсад хөгжлийн бэрхшээлтэй 101,000 орчим иргэн байна.⁷ Энэ нь нийт 3.24 сая хүн амын ердөө 3% гаруй гэсэн тооцоолол тул бодитой биш байж болох билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх тоог мөн дутуу гаргасан байж болзошгүй юм:

⁵ Хүүхдийг Ивээх Сан. 2016. *Тэгш хамруулах боловсрол: Юу, Яагаад, Хэрхэн: Хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд зориулсан гарын авлага*. Стокгольм.

⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллага. 2016. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо Ерөнхий зөвлөмж 4 (2016) Тэгш хамруулах боловсрол эзэмших эрх. CPRD/C/GC 4. Женев.

⁷ Монгол Улсын Засгийн Газар. 2017. *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллыг дэмжих тухай үндэсний хөтөлбөр, 2018–2022*. Улаанбаатар.

2018 онд тус улсын нийгмийн халамжийн мэдээллийн санд хөгжлийн бэрхшээлтэй 11,244 хүүхэд бүртгэлтэй байгаа ба үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхэд бүр албан ёсны оношилгоонд хамрагддаггүй ч нийгмийн халамжийн тэтгэмжид хамрагдахын тулд эрүүл мэндийн албан ёсны магадлагаа шаардлагатай байдаг.⁸ Бидний хийсэн судалгаагаар үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 700 орчим хүүхдийн хувьд таван хүүхэд тутамд ердөө нэг нь л албан ёсны оношилгоонд хамрагдсан байна (дэлгэрэнгүй мэдээлэл Бүлэг 2-т). Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын зүгээс дэлхийн хүн амын 15 орчим хувь нь, хүүхдүүдийн 1.5–5 орчим хувь нь хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй байдаг гэж үздэг (ДЭМБ, Дэлхийн Банк 2011). Дэлхийн дундаж тархалттай хамааруулан авч үзвэл Монгол Улсад 485,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид, хамгийн ихдээ 59,150 хүүхэд байх боломжтой. Тэрчлэн, Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа (ОУТС) зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэд болон хүүхдүүдийн тархалтын талаарх болон холбогдох бусад чухал мэдээлэл тусгагдсан байдаг.

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүн амын бусад бүлгийнхнээс ядуу байх магадлал өндөр байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг тэгш хамруулан авч үзсэн анхны бие даасан төслийн (дэлгэрэнгүй мэдээлэл удиртгал хэсэгт) баримт бичгийг боловсруулахад ашигласан 2016 оны судалгаанаас харахад ядуурлын хувь нь хөгжлийн бэрхшээлтэй нэг эсвэл түүнээс олон гишүүнтэй өрхүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнгүй өрхүүдтэй харьцуулахад хоёр дахин өндөр байна.⁹ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боловсрол эзэмших, ур чадвараа хөгжүүлэхэд нь болон үүнээс улбаалаад цалин сайтай ажил хөдөлмөр эрхлэх төдийгүй нийгмийн бусад үйл хэрэгт оролцоход нь тулгарч буй материаллаг орчин, зардал санхүү болон соёлоос үүдсэн саад бэрхшээлийн улмаас ядуу байх хандлага илүү өндөр байна. Монголд хөдөлмөр эрхлэх насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн таван хүн тутмын нэг (19%) нь ажил эрхэлж байгаа бол хөдөлмөрийн насны бусад хүмүүсийн бараг гуравны хоёр (64%) нь ажил эрхэлж байгаа нь эрс ялгаатай дүр зураг юм (АХБ 2019б).

7. 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хуулинд сурч боловсрох эрхийг хуульчлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн ажиллахад сургуулийн зүгээс хүлээх үүрэг, хүүхдээ сургуульд суралцуулах талаар эцэг эхийн хүлээх үүрэг, мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх талаарх нийгмийн ажилтны үүргийг тус, тус тодорхойлсон байна.¹⁰ Гэвч хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд ердийн сургуулийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй хэвээр байгаа ба тэдний боловсролын түвшин доогуур байгаа нь эмзэг байдлын гол шалтгаан болж байна. Ерөнхийд нь авч үзвэл Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй таван хүн тутмын нэг нь ямар ч түвшний боловсрол эзэмшээгүй байдаг бол бусад иргэдийн хувьд энэ үзүүлэлт 4%-аас бага байдаг байна.¹¹

⁸ АХБ. 2019в. *Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоо: Зардлын хуваарилалт ба үр шим хүртээгчдийн тухай мэдээлэл*. Зөвлөхийн тайлан. Манила (ТТ 8845-МОН).

⁹ АХБ. 2019б. *Хөгжлийн бэрхшээлтэй хүн Монголд хэрхэн амьдардаг вэ: Тэгш хамралт руу чиглэсэн ахиц дэвшил*. Манила.

¹⁰ 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Монгол Улсын хуулийн 4.1.1-д хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн хэмээн тодорхойлсон. Энэ тодорхойлолт нь хөгжлийн бэрхшээл бол дан ганц эрүүл мэндийн нөхцөл байдалтай холбоотой биш мөн нийгэм болон орчны бусад саадаас хамаарч байдгийг хүлээн зөвшөөрсөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцтой нийцэж байна.

¹¹ АХБ. 2019а. *Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог хангах нь. Ажиглалт ба саналууд 2019-02*. Манила.

8. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС)-ийн мэдээллээс харахад 2010 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаас бага хувь (44%) нь ердийн сургуульд суралцаж байжээ.¹² Энэ байдал сүүлийн 10 жилийн хугацаанд сайжирсан боловч бусад хүүхэдтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт ялангуяа алслагдсан хөдөө орон нутагт доогуур хувьтай хэвээр байна. Үүнийг бичиг үсэгт тайлагдалт дахь эрс зөрүүтэй байдлаас харж болно: 2014 онд 6–18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бараг тэн хагас нь, харин бусад хүүхдийн 4% нь унших чадварын хувьд муу үзүүлэлттэй байжээ. 3–5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бараг гуравны хоёр (64%) нь, харин бусад хүүхдийн гуравны нэг нь (32%) цэцэрлэгт хамрагдахгүй байна (АХБ 2019а). Тэрчлэн боловсролд хамрагдсан байдал хүйсийн хувьд ялгаатай байна — нийт хүн ам болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн аль алиных нь хувьд ахлах ангиудад хөвгүүдийн эзлэх хувь буурч байна.


9. **Хөгжлийн бэрхшээлийг өргөн утга агуулгаар нь ойлгох нь.** Монгол Улс 1990-ээд оны дунд үеэс эхлэн социалист бөгөөд төвлөрсөн тогтолцооноос ардчилсан, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжихэд боловсролын салбарт олон шинэчлэл хийгдсэний зэрэгцээ эмзэг бүлгийн болон үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдэд хандах нийгмийн хандлага өөрчлөгдсөн. Сүүлийн үеийн судалгаануудаас харахад монгол багш нар тэгш хамруулах боловсролыг ихэвчлэн бие эрхтэний бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд хамруулах явдал гэж үздэг хэвээр байна.¹³ Энэхүү явцуу үзэл нь “согог зүйчид/дефектологчид” хэмээн нэрлэгддэг мэргэжилтнүүд (тусгай боловсролын багш нар)-ийг тифлопедагогика (хараагүй суралцагчдад заах), сурдопедагогика (сонсголгүй суралцагчдад заах), олигофренопедагогика (танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдүүдэд заах) чиглэлээр бэлтгэдэг байсан Зөвлөлт Холбоот Улсын үеийн тусгай боловсролын тогтолцооны нөлөөлөл байж болох юм (Хүүхдийг Ивээх Сан 2018). Тэрчлэн, багш нарын үзэл бодолд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг илэрхийлдэг монгол хэлээрх нэр томъёо нь хөгжлийн асуудалтай хүүхдүүд эсвэл бие махбодын хувьд согогтой хүүхдүүд гэсэн утгатай байдаг нь нөлөөлсөн байж болох талтай. Бидний судалгаанд үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийг ангилахын тулд Вашингтон бүлэг/НҮБХС-ийн хүүхдийн үйлдлийн чадварын модулийг ашиглах замаар хөгжлийн бэрхшээлийг илүү өргөн утгаар нь авч үзсэн билээ (7 дугаар нүүр дэх судалгааны арга зүйг харна уу).

1.2 Боловсролын хүртэмж: Тоон мэдээллийн өнөөгийн дүр зураг

10. **Сургуулийн өмнөх боловсрол.** 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар Монгол Улсын 1,435 сургуулийн өмнөх боловсролын байгууллага (цэцэрлэгүүд)-д 261,350 гаруй хүүхэд хүмүүжин суралцаж байгаа ба хамран сургалтын цэвэр жин 75% байна. Ихэнх цэцэрлэг нь (бараг 93%) ердийн цэцэрлэг бөгөөд дөнгөж 6% гаруй нь хөдөө орон нутаг дахь гэр цэцэрлэгүүд юм. Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дөрвөн “тусгай” цэцэрлэг, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сувиллын таван цэцэрлэг байдаг. Цэцэрлэгт хамрагдаж буй нийт хүүхдийн ердөө 0.4% буюу 1,087 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд юм. График 1-ээс харахад цэцэрлэгийн тоо жил бүр нэмэгдэж байгаа боловч цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2017 оноос 2018 оны хооронд нэлээд буурчээ.

¹² НҮБХС. 2016б. *Монгол дахь НҮБХС-ийн Улс орны хөтөлбөр 2017–2021*. Улаанбаатар.

¹³ Хүүхдийг Ивээх Сан. 2018. *Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь төслийн хэрэгцээг тодорхойлох судалгаа*. Улаанбаатар: Хараат бус судалгааны хүрээлэн.




11. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо харьцангуй цөөн байгааг хэд хэдэн хүчин зүйлсийн хүрээнд тайлбарлаж болох юм. Хуулинд зааснаар хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэлх хүүхэд энгийн ангид хамрагдах боломжтой. Гэвч хөгжлийн бэрхшээлийг албан ёсоор тодорхойлох, оношлох явдал сул бөгөөд тохиромжтой үнэлгээ хийгддэггүй тул цэцэрлэгийн багш нар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн түвшинг өөрсдөө тодорхойлох шаардлагатай болдог. Хөгжлийн бэрхшээлийн төрөл болон хүндрэлийн түвшнээс болоод багш нар хүүхдүүдтэй ялгавартай байдлаар харьцах магадлалтай байж болох билээ. Цэцэрлэгийн нэг анги хэт олон буюу 35–40 хүүхэдтэй тул ажлын өндөр ачаалал болон туслах багшийн ба бусад төрлийн тусламжгүй тохиолдолд багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг энгийн ангид суралцахаас халширдаг.

12. Зөвхөн эрүүл мэндийн байгууллагууд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг бага насанд нь оношилгоонд хамруулж, илрүүлдэг тул анхаарлын дутмагшил, зан үйл, танин мэдэхүй болон суралцахуйн бэрхшээл зэрэг хөгжлийн бусад бэрхшээлийг эрт илрүүлэх явдал хязгаарлагдмал байдаг. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй олон хүүхэд оношилгоо хийлгээгүй байдаг нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо бага байгаагийн нэгэн тайлбар байж болох юм.

13. **Ердийн сургуулиар олгох суурь боловсрол.** Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам (БСШУСЯ)¹⁴ (2020 оны 7 дугаар сард Боловсрол, Шинжлэх Ухааны Яам болсон) 2016 онд суралцагчид, багш нар, сургуулийн удирдах ажилтан, сургалтын орчин, сурах бичиг болон санхүүжилтийн талаарх үндсэн статистик мэдээллийг агуулсан боловсролын салбарын мэдээллийн системийг (www.esis.edu.mn) үүсгэсэн. Аймаг, дүүргийн түвшний боловсролын мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх мэдээллийг тус системд оруулдаг. Сүүлийн таван жилийн хугацаанд [ердийн сургуульд хамрагдаж буй] хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэлээд буурсан (График 2) боловч [хөгжлийн бэрхшээлийг] илрүүлэх арга зүй нь найдвартай биш тул үүнийг боловсролын мэргэжилтнүүд тайлбарлах боломжгүй байна.

¹⁴ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам нь 2020 оны 7 дугаар сард Боловсрол, Шинжлэх Ухааны Яам болон өөрчлөгдсөн. Энэ тайланд БСШУСЯ-ны нэрийг ашигласан болно.



14. Хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг багш нар ихэвчлэн эмчийн магадлагаа болон/эсвэл эцэг эхчүүдийн өгсөн мэдээллээс мэддэг боловч аутизмын хүрээний эмгэг (АХЭ), анхаарлын дутмагшил болон хэт хөдөлгөөнтөх эмгэг (АДБХХЭ), суралцахуйн бэрхшээл зэрэг хөгжлийн бэрхшээлийн зарим төрлийг тэд өөрсдийн ойлголтын хүрээнд оношилдог. Тэгш хамруулах боловсролын талаар 2018 онд Хүүхдийг Ивээх Сангаас хийсэн судалгаанд бүхий л ердийн сургуулийн сургалтын менежерүүдийн өгүүлснээр багш нар тааруу суралцдаг бүх хүүхдийг суралцахуйн бэрхшээлтэй, хэт хөдөлгөөнтэй хүүхдүүдийг АДБХХЭ-тэй гэж үздэг гэж байна (Хүүхдийг Ивээх Сан 2018). Энэ нь боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн тодорхойлолт болон ангиллын тогтолцоо байхгүйтэй холбоотой юм.

15. 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хуулийн 16.2-т бүх шатны боловсролын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах мэдлэг, арга барил эзэмшсэн байхыг заасан байна. Гэвч энэхүү хууль болон сургуулиудын үйл ажиллагааны бодит байдал хоёрын дунд ихээхэн зөрүү байна. Хүүхдийг Ивээх Сангаас хийсэн хэрэгцээг тодорхойлох судалгаагаар ердийн сургуулийн багш нарын 88% нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах талаар сайтар бэлтгэгдээгүй гэдгийг бататгасан байна (Хүүхдийг Ивээх Сан 2018). Бүлэг 4-т бодлого, бодит байдал хоёрын зөрүүтэй байдлын талаарх судалгааны үр дүнгүүдийг танилцуулна.

16. **Тусгай сургуулиуд.** Улаанбаатар хотод зургаа, Дархан-Уул аймагт нэг тусгай сургууль байдаг. Нийслэл хот дахь тусгай сургуулиуд (Хүснэгт)-ын нэг нь харааны бэрхшээлтэй суралцагчдад, нэг нь сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулагдсан ба үлдсэн дөрөвт нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүд хамрагддаг. 2017–2018 оны хичээлийн жилд эдгээр сургуульд 1,637 хүүхэд суралцаж байжээ. Өөр, өөр төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх чадавх сургуулиудад ялгаатай түвшинд байна: 25 болон 63 дугаар сургуулиуд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд илүү чиглэсэн бол 55 дугаар сургууль “сэтгэхүйн хоцрогдолтой” хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулах чиглэл баримталдаг.

Хүснэгт 1: Улаанбаатар хот дахь тусгай сургуулиудад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2017–2018

Тусгай сургууль	Ангилал	Бүгд	Охид	Хөвгүүд	Бага анги	Дунд анги	Ахлах анги
55-р сургууль	Оюуны бэрхшээл	478	200	278	247	182	49
63-р сургууль	Оюуны бэрхшээл	233	97	136	116	117	...
29-р сургууль	Сонсголын бэрхшээл	315	140	175	133	120	62
116-р сургууль	Харааны бэрхшээл	104	42	62	65	34	5
25-р сургууль	Оюуны бэрхшээл	208	83	125	106	103	...
70-р сургууль	Оюуны бэрхшээл	299	113	186	189	110	...
Бүгд		1,637	675	962	856	665	116

(...) = мэдээлэл байхгүй.


Эх сурвалж: Хараат бус судалгааны хүрээлэн. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

17. **Насан туршийн боловсролын төвүүд.** Засгийн газрын агентлаг болох Насан туршийн боловсролын үндэсний төв (НТБҮТ)-ийн харьяа Насан туршийн боловсролын төв (НТБТ)-үүд нь дараах зорилгуудыг хэрэгжүүлдэг, үүнд сургуулийн гадна буй хүүхдүүдийн тоог бууруулах; сурч боловсрох эрх нь хязгаарлагдмал эмзэг бүлгийн хүүхдүүдэд бичиг үсгийн сургалт явуулах, боловсрол олгох; ажилгүй болон орлого багатай иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний сургалт явуулах; мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулахын зэрэгцээ НТБТ-ийн багш нарын чадавхыг бэхжүүлэх; амьдрах ухаан, экологи, эрүүл мэнд, иргэний болон тогтвортой хөгжлийн чиглэлээр боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг болно.

18. 2019 оны байдлаар 21 аймаг, нийслэлийн есөн дүүрэгт 355 НТБТ ажиллаж насан туршийн боловсрол болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтууд зохион байгуулж байна. Насан туршийн боловсролын хөтөлбөрүүдэд амьдрах ухааны ур чадвар, гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, ёс зүйн боловсрол, гоо зүйн боловсрол болон байгалийн ухааны боловсролын хөтөлбөрүүд багтдаг. Дүйцүүлэх хөтөлбөрийн хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний сургалтууд, амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөрүүд хэрэгждэг. НТБТ-ийн бага боловсролын хөтөлбөр нь монгол хэл; математик; зураг, урлаг, технологи; хүн ба байгаль, эрүүл мэнд гэсэн дөрвөн төрлийн хичээлээс бүрддэг.

19. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах журам нь НТБТ-үүдэд ялгаатай байдагтай адил багш нарын хандлага бас өөр, өөр байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зөвхөн дүйцсэн хөтөлбөрийн сургалтад л хамруулдаг олон багш байдаг. 2018–2019 оны хичээлийн жилд 355 НТБТ-д сурч байсан 7,296 хүүхдийн 933 (12.8%) нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байжээ (бага боловсролын түвшний 42.1%, бүрэн бус дунд боловсролын түвшний 47.2%, бүрэн дунд боловсролын түвшний 10.7%). Найман аймгийн НТБТ хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гэр бүлд суурилсан сургалт явуулдаг ба 2018–2019 онд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 72 хүү, 59 охин гэр бүлд суурилсан сургалтад хамрагдсан байна.

20. **Сургуулийн гадна буй хүүхдүүд.** Бага, дунд боловсролын тухай хуулийн 20.2.8 дахь заалтын дагуу бүх сургууль, цэцэрлэгийн удирдлагууд хамран сургах тойргийнхоо хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх үүрэг хүлээдэг. Хамран сургах тойргийг Улаанбаатар хот болон аймгуудын Боловсрол соёлын газраас тогтоодог. Сургууль, цэцэрлэгээс завсардсан бүртгэлийг хороон дээр хийдэг боловч бүртгэл мэдээллийг тогтмол шинэчилдэггүйн улмаас сургууль завсардалтын бодит нөхцөл байдлыг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. 2018-2019 оны хичээлийн жилийн талаарх ҮСХ-ны мэдээллээс харахад сургуулийн насны ердөө 759 хүүхэд сургуульд суралцахгүй байна (График 3). Эдгээр хүүхдийн 70 орчим хувь нь сургуульд хэзээ ч сурч байгаагүй бол үлдсэн хувь нь сургуулиас завсардсан байна. Гэвч 2019 онд НТБҮТ-өөс хоёр аймаг, Улаанбаатар хотын гурван дүүрэгт хийсэн судалгаагаар ҮСХ-ны мэдээтэй харьцуулахад маш олон тооны хүүхэд сургуулиас завсардсан байсан ба тэдний дотор бага боловсролын түвшний 6-10 настай хүүхдүүд илүү өндөр тоотой байгаа нь харагдсан байна.¹⁵



21. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос сургууль завсардалтын гол шалтгаануудыг хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, ядуурал буюу өрхийн нийгэм-эдийн засгийн байдал гэж үзсэн байна.¹⁶ Хүүхдийг Ивээх Сангийн 2018 оны судалгаанд тусгай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үүнд хамаарна) хүүхдүүдийн сургуулиас завсардах үндсэн шалтгаан нь (i) өрхийн санхүүгийн нөхцөл байдал болон/эсвэл эцэг эхийн анхаарал халамж тааруу байдал; (ii) сургуулийн дэд бүтэц, анги танхим болон сургалтын материалын хангалтгүй бөгөөд тохиромжгүй байдал; (iii) хөгжлийн бэрхшээлээс үүдсэн эрүүл мэндийн нөхцөл байдал гэж үзжээ (Хүүхдийг Ивээх Сан 2018). Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ихэнхдээ байнгын асаргаа шаардлагатай байдаг. НТБҮТ-ийн 2019 оны судалгаанаас харахад 6–18 насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 3,372 хүүхэд байна. Өмнө нь дурьдсанаар эдгээр хүүхдийн дөнгөж 131 нь буюу 3.8% нь НТБТ-ийн гэр бүлд суурилсан сургалтад хамрагдаж байна.

1.3 Судалгааны арга зүйн талаарх товч мэдээлэл

22. Албан хэрэгцээний энэхүү баримт бичигт АХБ-ны захиалгаар Хараат бус судалгааны хүрээлэнгээс 2019 онд Монгол Улсын зарим аймаг, дүүрэгт хийсэн асуулга, чанарын судалгааны мэдээллийг толилуулж байгаа билээ (ХБСХ, Улаанбаатар). Тус судалгааг АХБ-

¹⁵ НТБҮТ. 2019. *Сургуулийн гадна буй хүүхдүүдийн судалгаа*. Насан туршийн боловсролын үндэсний төвийн асуулга судалгааны тайлан. Улаанбаатар хот.

¹⁶ Хүний эрхийн үндэсний комисс. 2018. *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт ба сургууль завсардалт*. Хэвлэгдээгүй.

аас Тэгш хамруулах боловсролыг дэмжих буцалтгүй тусламжийн шинэ төслийг боловсруулах үйл явцад сонгогдсон орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдахад тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох зорилгоор хийсэн. Судалгаа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн үзэл баримтлал дээр тулгуурласан ба өрхийн өргөн хэмжээний асуулга; дэлгэрэнгүй ярилцлага; эцэг эхчүүд, багш нар, сургуулийн удирдлагууд, нийгмийн ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлэг бүхий тоон болон чанарын судалгааны аргуудыг хэрэглэсэн. Судалгааны багийнхан Дархан-Уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5,328 өрхөөс тоон судалгаа авсан. Хөвсгөлөөс бусад дээр дурдсан газруудыг БСШУСЯ-тай зөвшилцөн АХБ-ны буцалтгүй тусламжийн төслийн зорилтот орон нутаг болгохоор сонгосон. 2019 оны 9 дүгээр сард ХБСХ, АХБ хамтран асуулга судалгааны үр дүн, зөвлөмжүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага зэрэг иргэний нийгмийн байгууллагуудаар Улаанбаатар хотноо хэлэлцүүлэн баталгаажуулсан. Иргэний нийгэм, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хийсэн хэд хэдэн нэмэлт хэлэлцүүлэг нь тэрчлэн буцалтгүй тусламжийн шинэ төслийн бүтцийг боловсруулахад хувь нэмрээ оруулсан.

23. АХБ-ны асуулга судалгаанд хүүхдийн үйлдлийн чадварын хүндрэлийг тодорхойлох Вашингтон бүлэг/НҮБХС-ийн модулийг ашигласан.¹⁷ Үйлдлийн чадварын хүндрэлүүд нь тохиромжгүй орчинд байх үед хүүхдийн хөгжилд шууд нөлөө үзүүлж болох өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай үндсэн ур чадваруудын хувьд тулгарах бэрхшээлүүд юм. Тус модуль нь 2–5 настай хүүхдийн хувьд найм, 6–17 настай хүүхдийн хувьд 12 айн хүрээнд үйлдлийн чадварын стандартуудыг хянан үздэг (Хүснэгт 2). Тус асуулгад 5,328 өрхийн 2–17 насны 9,555 хүүхдийг хамруулсан (Хүснэгт 3).

Хүснэгт 2: Вашингтон бүлгийн үйлдлийн чадварын ангилал

2–5 настай хүүхдүүд	6–17 настай хүүхдүүд
Харах	Харах
Сонсох	Сонсох
Алхах	Алхах
Жижиг булчингийн хөгжил	Өөрийгөө арчлах
Харилцах ба/эсвэл ойлгох	Харилцах ба/эсвэл ойлгох
Суралцах	Сурах
Тоглох	Ой тогтоолт
Үйл хөдлөлөө хянах	Анхаарлаа төвлөрүүлэх Өөрчлөлтийг хүлээн авах Үйл хөдлөлөө хянах Найзтай болох Сэтгэл хөдлөл (түгших, сэтгэлээр унах)

Эх сурвалж: НҮБХС. 2016а. *Хүүхдийн үйлдлийн чадварын модулийн асуулга*. Нью-Йорк.

¹⁷ Вашингтон бүлэг/НҮБХС-ийн Хүүхдийн үйлдлийн чадварын модулийг 2016 онд эцэслэн боловсруулсан ба 2-17 насны хүүхдүүдийн сонсох, харах, харилцах ба/эсвэл ойлгох, сурах, алхах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх зэрэг айгаарх үйлдлийн чадварын хүндрэлд үнэлгээ хийхэд ашигладаг. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлийн түвшинг илүү сайн тогтоохын тулд ай бүрийг тогтоосон шатлалтай харьцуулан үнэлдэг. Үүний зорилго нь насны хувьд нэг бүлгийн бусад хүүхэдтэй харьцуулахад арай илүү эрсдэлд байгаа эсвэл тохируулгат бус орчинд оролцоо нь хязгаарлагдмал байдаг тухайн насны бүлгийн хүүхдүүдийн дэд бүлгийг тодорхойлон тогтоох явдал юм. Мэдээллийг <https://data.unicef.org/resources/module-child-functioning/> холбоосоос авсан.

24. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 874 нь буюу 9% хувь нь үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй гэж тогтоогдсон. Үүнээс 2–5 насны 106 хүүхэд, 6–17 насны 768 хүүхэд байв. Байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр хувьтай (12.9%), харин Дорнод аймагт хамгийн бага хувьтай (6.3%) байна. Судалгааны багийнхан ҮСХ-ны 2018 оны ОУТС-ны үр дүнтэй харьцуулахад хүүхдүүдийн нэлээд өндөр хувь нь үйлдлийн бэрхшээлтэй байгааг илрүүлсэн байна. Судалгааны арга зүйн ялгаатай байдлаас шалтгаалаад ҮСХ-ны судалгааны үр дүнгүүд нь дөрвөн хувийн доогуур үзүүлэлттэй байна: ҮСХ нь судалгаандаа үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлийн арай хязгаарлагдмал тодорхойлолтыг ашигласан.¹⁸

Хүснэгт 3: Судалгаанд хамрагдсан өрх болон хүүхдийн тоо

	Бүгд	Байршил				
		Дорнод	Дархан-Уул	Дундговь	Хөвсгөл	Улаанбаатар
Өрх						
Ярилцлагад хамрагдах шалгуур хангасан өрхүүд	7,563	2,141	2,272	965	179	2,006
Ярилцлагад хамрагдсан өрхүүд	5,296	1,518	1,437	615	162	1,564
Ярилцлагад хамрагдсан өрхийн хувь	70.4	66.3	64.9	65.7	95.0	81.3
Хүүхдийн тоо						
Ярилцлагад хамрагдсан	9,555	2,521	2,713	1,065	291	2,965

Тайлбар: Шалгуур хангасан өрхүүдийн гуравны нэг нь буюу 29.6% нь холбогдох боломжгүй эсвэл асуулгад оролцохоос татгалзсан. Ярилцлагад хамрагдсан өрхийн хувь буюу хариултын түвшинд нөлөөлсөн гол хүчин зүйл нь цаг хугацааны нөхцөл байдал байлаа—мэдээлэл цуглуулах хугацаа нь 7 дугаар сард болдог үндэсний баяр болох Наадам болон зуны амралттай давхцсан. Өрх бүртэй хамгийн багадаа гурван удаа холбогдох гэж оролдсон.

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн тусалцааны зөвлөхийн тайлан. Манила.

25. Мэдээлэл цуглуулах ажлын хоёр дахь үе шатанд 2–17 насны (нийт 1,337 хүүхдээс) хөгжлийн бэрхшээлтэй 657 хүүхэд бүхий 562 өрхөөс нэмэлт мэдээлэл авах судалгааг хийсэн. Нийт өрхийн 44% нь Улаанбаатар хотынх.¹⁹ Өрхийн гишүүдийн дундаж тоо 4.5 ба өрхүүдийн талаас дээш нь 5–7 гишүүнтэй. Өрхүүд дунджаар 2.4 хүүхэдтэй ба нийт өрхийн тавны нэг (21.5%) нь өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий өрх байна (үндэсний дундаж 19.3%). 10 өрхийн тэргүүн тутмын нэг нь боловсролгүй (10.3%) байгаа нь үндэсний хэмжээний дундаж болох

¹⁸ ҮСХ-ны судалгаанд сэтгэлээр унах болон гуниглах явдал өдөр бүр тохиолддог хүүхдүүдийг л сэтгэл түгших хүндрэлтэй гэж үзсэн бол ХБСХ-ийн судалгааны багийнхан өдөр бүр эсвэл долоо хоног бүр (бусад хариултын сонголт нь сардаа нэг удаа, жилдээ нэг удаа) гэж хариулсан хүүхдүүдийг тус хүндрэлтэй гэж үзсэн. Вашингтон бүлгээс судалгааны зорилтууд, хам орчин, арга зүйгээс шалтгаалан өдөр бүр эсвэл долоо хоног бүр гэж хариулсан хүүхдүүдийг үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй гэж үзэхийг зөвлөмжилдөг. Тэрчлэн ҮСХ нь тодорхой үйлдлийг хийж чадахгүй гэж хариулсан хүүхдүүдийг тухайн үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй гэж үзсэн бол ХБСХ нь тухайн үйлдлийг гүйцэтгэхэд хэцүү байдаг гэж хариулсан хүүхдүүдийг мөн хамруулан үзсэн.

¹⁹ Энэ нь хүн амын тархалтын байдлыг төлөөлөх чадвар сайтай байна: Улаанбаатар хотын хүн ам 1.5 сая бөгөөд улсын нийт 3.24 сая хүн амын ойролцоогоор 46%-ийг эзэлдэг.

3.6%-аас маш өндөр үзүүлэлт бөгөөд гуравны нэгээс арай их хувь нь бүрэн бус дунд эсвэл түүнээс доош түвшний боловсролтой (36.5%) байгаа бол үндэсний хэмжээнд дөрөвний нэг нь ийм боловсролын түвшинтэй байдаг байна. Ээжүүдийн боловсролын түвшний хувьд 11.5% нь боловсролгүй, 30% нь бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна (бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй ээжүүдийн эзлэх хувийг аавуудынхтай харьцуулахад 12%-аас дээш үзүүлэлттэй байна). Сургуулийн насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт 98% байна. Ихэнх хүүхдүүд (72%) эцэг, эхийнхээ хоёулангтай нь хамт амьдарч байгаа бол 19% нь зөвхөн ээжтэйгээ хамт амьдарч байна.

26. Нэмэлт мэдээлэл авах судалгаагаар тэрчлэн [өрхүүдийн] нийгэм-эдийн засгийн байдалтай холбоотой төрөл бүрийн мэдээлэл цуглуулж, холбогдох аж байдлын индексийг тогтоосон. Асуулга судалгааны үр дүнг бүтнээр нь болон аж байдлын индексийн зэрэглэлийг тодорхойлсон индикаторуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ХБСХ-ийн судалгааны бүрэн хэмжээний тайлангаас харах боломжтой²⁰ ба энд [өрхүүдийн] нийгэм-эдийн засгийн байдлыг өргөн хүрээнд харуулсан зарим цөөн үр дүнг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Нэгдүгээрт, өрхүүдийн нэлээд олонх (87%) нь үндэсний дунджаас доогуур орлоготой байна.²¹ Өрхүүдийн бараг гуравны нэг (31%) нь гэрт амьдардаг (үндэсний дундаж нь 37%) ба тэдний талаас дээш хувь нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байна. 10 өрх тутмын найм нь өөрсдийн гэртээ амьдардаг ба үлдсэн нь хөлсний гэрт/байранд амьдардаг. Бараг бүх өрх цахилгаан хангамжтай (ердөө дөрвөн өрх цахилгааны холболтгүй ба эдгээрийн хоёр нь Улаанбаатарт байдаг), 10 өрх тутмын 4 нь интернетийн холболттой ба бүх өрхийн хувьд хамгийн багадаа нэг гишүүн нь гар утастай байна. Бараг бүх өрх (96%) зурагттай байна. Тээврийн хэрэгслийн хувьд 10 өрх тутмын ердөө дөрөв нь суудлын авто машинтай, дөрөвний нэг арай хүрэхгүй хувь (24%) нь унадаг дугуйтай ба 8% нь ачааны, суудлын том тэрэг эсвэл фургонтой байна. Мөн дөнгөж 4% нь мотоциклтэй байна.

27. Тэгш хамралтын индикаторууд—тэгш хамруулсан соёл, бодлого, практик үйл ажиллагаа, материаллаг орчин (Бүлэг 4)-ыг үнэлэхийн тулд тус судалгааны хүрээнд 6–17 насны хүүхэдтэй 556 эцэг эх, бага насны (2–5 настай) хүүхэдтэй 101 эцэг эх, 76 багш, сургуулийн нийгмийн ажилтан, 18 аймаг болон дүүргийн боловсролын мэргэжилтнүүдийг дэлгэрэнгүй ярилцлага болон фокус бүлгийн хэлэлцүүлэгт хамруулах замаар өргөн хүрээтэй чанарын судалгаа авсан. Тэрчлэн судалгааны багийнхан материаллаг орчны хүртээмжтэй байдлыг үнэлэх ажиглалтын хуудсыг бөглөх зорилгоор есөн сургууль, цэцэрлэг дээр ажилласан.

28. Нөөцийн хязгаарлагдмал байдлын улмаас тус судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлын хувьд хариуцлага хүлээх голлох насанд хүрэгчдийн үзэл бодол дээр суурилсан. Гэвч цаашид хүүхдүүдийн ямар үзэл бодолтой байгааг илрүүлэх судалгаа хийх хэрэгтэй гэсэн саналыг бид дэвшүүлж байна.

²⁰ ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банканд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

²¹ ҮСХ. 2020. *Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа 2018*. Улаанбаатар. 2018 онд үндэсний хэмжээнд өрхийн сарын дундаж орлого 1,181,067 төгрөг байв.


2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ БА СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТЫН ШАЛТГААНУУД

2.1 Хөгжлийн бэрхшээлийн төрлүүдийг тодорхойлох нь

29. АХБ-ны Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх асуулга судалгаагаар Вашингтон бүлэг/НҮБХС-ийн хүүхдийн үйлдлийн чадварын модуль (1.3 дахь хэсэг)-ийг ашиглан 2–17 насны хөгжлийн бэрхшээлтэй 657 хүүхдийг илрүүлсэн ба тэдний ердөө 19.6% нь хөгжлийн бэрхшээлтэй гэж өмнө нь албан ёсоор оношлогдсон байна. 2014 онд аймаг, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсээс 0–16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах болон түүнд хяналт-шинжилгээ хийх үүрэг бүхий эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссыг байгуулсан. Мөн тэр үед Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ)-ны харьяанд төв комисс байгуулагдсан. Албаны мэдээллээр 21 аймаг, есөн дүүрэг дэх бүх салбар комисс 2017 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа гэх боловч АХБ-ны тус судалгаагаар комисс нь ердөө цөөхөн тооны хүүхдийн оношийг баталсан гэдгийг тогтоосон байна. Комиссын үйл ажиллагаа болон үйлчилгээ нь бүх сум, хороонд хүрэхгүй хэвээр байна.

30. АХБ-ны тус судалгаанд хамрагдсан үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 10 хүүхэд тутмын найм нь дунд эсвэл хүнд түвшний бэрхшээлтэй байна (График 4). 2–5 насны хүүхдийн 22%, 6–17 насны хүүхдийн 16.7% нь нэгээс олон төрлийн бэрхшээлтэй байна. Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нь хүүхдүүд нийгмийн амьдрал, суралцах орчин болон өдөр тутам хийдэг үйл ажиллагааныхаа хувьд нэмэлт саад бэрхшээлтэй тулгарч байдаг гэсэн үг юм. Үүний улмаас тэдний боловсролын онцлог хэрэгцээ шаардлагад онцгой анхаарал хандуулах шаардлагатай билээ.

График 4: Хөгжлийн бэрхшээлийн зэрэг



■ Хөнгөн ■ Дунд ■ Хүнд ба хавсарсан

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

2.2 Боловсролын хүртээмж

31. ТХЗ 4.1 нь бүх охид, хөвгүүдийг суралцахуйн амжилтын хувьд зохистой бөгөөд үр дүнтэй байдал руу хөтөлсөн үнэ төлбөргүй, тэгш боломжийг хангасан бөгөөд чанартай бага, дунд боловсролд хамрагдах явдлыг баталгаажуулахыг зорьсон. Монгол Улсад хүүхдүүд 2–5 настайдаа сургуулийн өмнөх боловсролд (цэцэрлэгт), 6 настайгаасаа эхлэн

бага боловсролд, 12 настайгаасаа эхлэн бүрэн бус дунд боловсролд, 15 настайгаасаа эхлэн бүрэн дунд боловсролд хамрагддаг. 2018 оны ОУТС-аас харахад Монгол Улсын боловсролын хамран сургалт сургуулийн өмнөх боловсролын түвшинд 68%, бага боловсролын түвшинд 96%, дунд боловсролын түвшинд 93% байна.

32. АХБ-ны судалгаанд хамрагдсан 6–17 насны үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн ихэнх (96.2%) нь 2018–2019 оны хичээлийн жилийн байдлаар сургуульд суралцаж байна (Хүснэгт 4). Тэдний 95.2% нь ердийн сургуульд, 1.7% нь тусгай сургуульд, 1.4% нь техник, мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС)-ын байгууллагуудад суралцаж байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн 2.5% нь 6–10 настай, 3.5% нь 11–14 настай, 6.7% нь 15–17 настай байна. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын хувь өндөр байгаа нь 2018 оны ОУТС-ны үндэсний хэмжээний үзүүлэлттэй нийцэж байна. Тусгай сургуульд хамрагдаж буй хүүхдүүдийн эзлэх хувь Дархан-Уул аймагт (3.7%) болон арай том хүүхдүүдийн тухайд (11–14 настай хүүхдүүдийн 2.5%) илүү өндөр байна.²² Ахлах ангид (15–17 нас) суралцдаг үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн ердөө 88% нь ердийн сургуульд, 2% нь тусгай сургуульд, 7% нь ТМБС-д хамрагдаж байна.

33. Хүснэгт 5-д 2–5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын талаарх тоон мэдээллийг харууллаа: 2018–2019 оны хичээлийн жилд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн 63%, сургуулийн насны хүүхдүүдийн 96% нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа нь үндэсний дундажтай харьцуулахад арай доогуур үзүүлэлт юм. Дорнод аймаг болон Улаанбаатар хотод бага насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь нь бусад орон нутгийнхаас арай доогуур байгаа нь цэцэрлэгийн хүртээмжгүй байдал, нэг ангид хэт олон хүүхэд хамрагддаг болон асран хамгаалагчид нь хүүхдээ цэцэрлэгт хүргэж өгөх болон цэцэрлэгээс авах боломжгүй байдагтай холбоотойг ярилцлагаар тодруулсан. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн дийлэнх нь ердийн цэцэрлэгт хамрагдаж байна. Цэцэрлэгт явдаггүй хүүхдүүдийн ихэнх нь өмнө нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаагүй бөгөөд мөн тэдний олонх нь хөвгүүд байна.

34. Монгол Улсын 2018 оны НҮТС-аас харахад сургууль завсардалт бага боловсролын түвшинд 3.6%, бүрэн бус дунд боловсролын түвшинд 4.6%, бүрэн дунд боловсролын түвшинд 9.5% байна. АХБ-ны судалгааны багийнхан сургууль завсардалтын хувийг өөрсдийн тогтоосон өрхийн аж байдлын индекстэй харьцуулж үзэхэд өрхийн аж байдлын түвшний бага боловсролын түвшин дэх сургууль завсардалтад үзүүлэх нөлөөлөл бага байна. Гэвч бүрэн бус дунд боловсролын түвшнээс эхлээд өрхийн амьжиргааны хувьд доогуур түвшний хүүхдүүдийн сургууль завсардалтын хувьд нэмэгдэж байгаа ба ахлах ангийн түвшин огцом өссөн үзүүлэлттэй байна.²³ АХБ-ны судалгааны үр дүнгээс харахад үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн 3.8% нь сургуулиас завсардаад байна (15–17 настай хүүхдүүдийн 6.7%). Энэ асуудлыг цаашид дэлгэрүүлэн судлах хэрэгтэй: АХБ-ны судалгааны үр дүнгээр үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдийн 87% нь өрхийн орлогын хувьд үндэсний дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа тул 15–17 настай хүүхдүүдийн сургууль завсардалтын хувь үндэсний дундаж болох 9.5%-аас өндөр байх боломжтой гэж бид үзсэн боловч эсрэгээрээ үүнээс доогуур үзүүлэлттэй байлаа.

²² Дархан-Уул аймаг нь тусгай сургуультай цорын ганц аймаг бөгөөд бусад тусгай сургууль нь Улаанбаатарт байдаг.

²³ НҮБХС, ҮСХ. 2018. *Монгол: Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018*. Улаанбаатар.

Хүснэгт 4: Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 6–17 настай хүүхдүүдийн сургуульд хамрагдалт

	Сургуульд хамрагдалт 2018–2019 онд (%)		Сургуулийн төрөл (%)							6–17 насны хүүхдийн тоо	
	Сургуульд хамрагдсан	Сургууль завсардсан	Цацаргалт	Энгийн сургууль	Энгийн сургуулийн тусгай анги	Энгийн сургуулийн хүүхэд хөгжлийн төв	Тусгай сургууль	НТБТ	МСҮТ		Их сургууль
Нийт	96.2%	3.8%	0.8 %	95.2%	0.2%	0.4%	1.5%	0.0%	1.3%	0.6%	556
Байршил	94.6	5.4	0.0	97.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	2.3	92
Дорнод	97.3	2.7	0.9	91.7	0.9	0.0	3.7	0.0	1.8	0.9	113
Дундговь	96.2	3.8	0.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	79
Хөвсгөл	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	18
Улаанбаатар	96.1	3.9	1.3	94.0	0.0	0.9	1.7	0.0	2.1	0.0	254
6–10	97.5	2.5	1.6	97.3	0.0	0.4	0.8	0.0	0.0	0.0	278
11–14	96.5	3.5	0.0	96.3	0.6	0.6	2.5	0.0	0.0	0.0	172
15–17	93.3	6.7	0.0	88.1	0.0	0.0	2.0	0.0	6.9	3.0	105

НТБТ = Насан туршийн боловсролын төв, МСҮТ = мэргэжлийн боловсрол сургалтын төв.

Эх сурвалж: АЙРИМ. 2019. Тэгш хамруулах боловсролын дэмжих нь. Техникийн туслалцааны төслийн хүрээнд АХБ-нд зориулж зөвлөхийн бэлтгэсэн тайлан. Манила.

Хүснэгт 5: Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй 2–5 настай хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт

		Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт (%)		Цэцэрлэгийн төрөл (%)			Нийт хүүхэд
		Хамрагдсан	Хамрагдаагүй	Ердийн	Тусгай	Гэр	
Бүгд		63%	37%	94%	5%	2%	101
Байршил	Дорнод	56	44	100	0	0	18
	Дархан-Уул	71	29	87	13	0	21
	Дундговь	75	25	100	0	0	8
	Хөвсгөл	67	33	100	0	0	3
	Улаанбаатар	61	39	94	3	3	51
Нас	2	30	70	100	0	0	23
	3	52	48	92	0	8	25
	4	82	18	100	0	0	17
	5	68	32	85	15	0	19
	6	100	0	94	6	0	17

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

35. Сургуулийн гадна буй хүүхдүүдийн 81% нь хувийн шалтгааны улмаас, 14.3% нь гэр бүлтэй холбоотой шалтгааны улмаас, 2% нь сургуультай холбоотой шалтгааны улмаас сургуулиас гарсан гэж мэдэгдсэн. Асран хамгаалагч болон эцэг эхчүүдийн тайлбарласнаар сургуулиас гарахад нөлөөлсөн хувийн шалтгаанууд нь (давтамжийн дарааллаар) эрүүл мэндийн байдал, сурах сонирхолгүй байдал, өөрийгөө илэрхийлэх болон бусад хүмүүстэй харилцах чадваргүй эсвэл чадвар сул байдал юм. Сургуулиас гарахад нөлөөлсөн гэр бүлтэй холбоотой шалтгаанууд нь сургуульд суралцахтай холбоотой зардлыг төлөх боломжгүй байдал, шилжин суурьшилтаас үүдсэн асуудлууд, шаардлагатай бичиг баримтгүй байх, хүүхдийг сургуульд хүргэж өгөх болон сургуулиас авах хүнгүй байх явдал байна. Сургуультай холбоотой шалтгаанууд нь үе тэнгийнхний зүгээс дээрэлхэх явдал, багш нар болон сургуулийн бусад ажилтнуудын зүгээс үзүүлэх дарамт шахалт байна.

36. Улаанбаатар хот болон аймгуудын боловсролын газрын ярилцлагад хамрагдсан 20 албан хаагч сургууль завсардсан хүүхдүүдэд хүрч ажиллах болон тэднийг эргэн сургуульд хамруулахад дараах бэрхшээлүүд тулгардаг хэмээн тодорхойлсон (хариулт бүрийн давтамжийг ард нь хаалтанд бичив):

- (i) эцэг эх нь хүүхдүүддээ сурч боловсроход нь дэмжлэг үзүүлдэггүй бөгөөд хүүхдээ сургуульд суралцуулах сонирхолгүй (9);
- (ii) багш нарт сургууль завсардсан хүүхдүүдтэй ажиллахад нь дэмжлэг үзүүлэх механизм байхгүй (7);
- (iii) бүртгэл, хаягжуулалттай холбоотой үйл ажиллагаа сул бөгөөд тогтвортой бус (6);
- (vi) үе тэнгийнхний сөрөг хандлага (6);

- (v) хүүхдүүд сургуульд суралцах сонирхол багатай эсвэл огт сонирхолгүй (6);
- (vi) хууль тогтоомжид нийцсэн дүрэм журам байхгүй (5);
- (vii) сургуулийн удирдлага, багш нар болон бусад ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулахаас татгалздаг (4);
- (viii) багш, ажилтнуудын сөрөг хандлага (1).

37. Шигтгээ 1-д багш нар болон сургуулийн бусад ажилтны зүгээс үзүүлэх дэмжлэггүйн улмаас бага сургуулиа дүүргэсэн боловч дунд сургуулиас завсардсан нэгэн охины жишээг харуулав.

Шигтгээ 1: Сургууль дээрх дэмжлэг хангалтгүй

[Хөгжлийн бэрхшээлтэй нэгэн сурагч] үеийнхэнтэйгээ хамт дунд сургуульд суралцах боломжгүй болсон. Охиныг бага сургуульд суралцаж байх үед ээж нь тус сургуульд ажиллаж байсан тул [охиноо] олон талаар дэмжих боломжтой байсан ба хичээлд нь мөн тусалж байсан. Үүний үр дүнд [охин] суралцсаар бага сургуулиа дүүргэж чадсан. Харин дунд сургуульд ороход нь түүнд туслах эсвэл дэмжлэг үзүүлэх хэн ч байгаагүй. Сурагчид байтугай багш нар ч охинд туслахаас татгалзсан. Мөн сургуулийн орц, гарцны дэргэд налуу зам байгаагүй. Эдгээр шалтгааны улмаас охин сургуульд үргэлжлүүлэн суралцаж чадаагүй.

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нэгэн казак ээж, 2019 оны 8 дугаар сарын 3.

3. ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ, БОДЛОГЫН ХҮРЭЭ МОНГОЛ УЛСАД

38. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн Монгол Улсын хууль эрх зүйн зохицуулалтын хүрээ нь олон асуудлыг хамарсан цогц шинжтэй ба сүүлийн таван жилд батлагдсан хэд хэдэн гол хууль болон 2018 оноос эхлэн БСШУСЯ-аас баталсан зарим бодлого, журмаас бүрдэж байна. Гэвч хурдацтай хөгжлийн улмаас бодлого болон бодит амьдрал дээрх хэрэгжилт хоёрын хооронд ихээхэн зөрүү байна. Энэ бүлэгт голлох бодлогууд болон тэдгээрийн хэрэгжилтийн талаарх АХБ-ны судалгаанд хамрагдсан зарим эцэг эхчүүдийн үзэл бодлыг тусгалаа.

3.1 Үндэсний түвшний бодлогууд

39. **Боловсролын тухай хууль, 2006 он.** Хуулийн 5.1.4-т *Монгол Улсын иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана* гэж заажээ. Судалгаанд хамрагдсан сургуулийн насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн 3%, цэцэрлэгийн насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн 9% нь хүүхдүүдийг нь анх сургууль эсвэл цэцэрлэгт орох үед бодлогын орчин нь тэдний хувьд ээлтэй биш байсан гэсэн бол эцэг эхчүүдийн 12.6% нь хүүхдүүд нь сургуулийн дүрэм журмыг дагаж мөрдөхөд бэрхшээлтэй тулгарч байсан гэжээ.

40. **Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014–2024 он)**-д албан болон албан бус боловсролын нийт байгууллагыг бүх насны иргэдийн боловсролын хэрэгцээнд

нийцсэн үйлчилгээ үзүүлэх чадамжтай байх ёстой хэмээн тусгасан. АХБ-ны асуулга судалгаагаар эцэг эхчүүдээс хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд нь тохируулан сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах боломжтой эсэхийг асуухад цэцэрлэг болон сургуулийн насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн аль алиных нь гуравны нэг орчим хувь нь хөтөлбөрт тохируулгат өөрчлөлт оруулах боломжгүй байх гэж хариулсан. Эцэг эхчүүдийн талаас илүү хувь (56%) нь хүүхдийнхээ хэрэгцээн дээр суурилан хоцрогдол нөхөхийн тулд хувийн багшаар хичээл заалгах боломжгүй гэж үзсэн.

41. Тогтвортой хөгжлийн зорилго 4: Тэгш хамруулсан ба тэгш боломжийг хангасан боловсрол. ТХЗ 4-ийн хүрэх үзүүлэлт 4.5 нь боловсрол дахь хүйсийн тэгш бус байдлыг арилгах болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уугуул иргэд, эмзэг нөхцөлд буй хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхнийг боловсролын бүхий л түвшин болон мэргэжлийн сургалтад тэгш хамруулах явдлыг баталгаажуулахад чиглэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар хөгжлийн *бэрхшээлгүй* хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүд ямар ойлголт, хандлагатай байдаг нь мөн чухал билээ. АХБ-ны асуулга судалгаанд хамрагдсан багш нарын 13% нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хамт суралцаж буй хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн зүгээс гомдол хүлээж авч байсан гэж хариулсан.

42. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2016 он. Тус хуульд 2016 онд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг цэцэрлэгийн багшид нэмэгдэл цалин олгох асуудлыг онцгойлон тодорхойлсон билээ. Хүүхэд нь цэцэрлэгт хамрагдаж буй эцэг эхчүүдийн 28% орчим нь цэцэрлэгээс баримталдаг бодлого, журмын талаарх мэдээллийг цэцэрлэгийн ажилтнуудаас авдаг ба 15% нь цэцэрлэгийн бодлого, журмуудыг цэцэрлэгийн үүдний хэсэгт байрлуулсан байдаг гэж хариулсан. Эцэг эхчүүдийн бараг гуравны нэг (30%) нь хүүхдүүд нь гэрээсээ нэлээд хол байдаг цэцэрлэгт хамрагддаг гэдгийг дурдсан.

43. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он. Тус хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боловсрол болон мэргэжлийн боловсролд адил тэгш хамрагдах ба боловсролын бүхий л байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй суралцах орчинг баталгаажуулах үүрэгтэй хэмээн заажээ. АХБ-ны асуулга судалгаагаар зарим аймаг өөрсдийн санхүүжилтээр ердийн сургуулиудын дэргэд тусгай анги, дугуйлан хичээллүүлэх зэрэг сайн үйлчилгээ үзүүлдгийг тодруулсан. Хуулийн 16.2 дахь заалтад бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байхыг тусгажээ. Гэвч асуулга судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлийн талаарх багш, нийгмийн ажилтнуудын мэдлэг ойлголт нэлээд хангалтгүй байна. Зарим аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудал дагнан хариуцсан мэргэжилтэн ажилладаг бол зарим аймагт бага боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн энэ үүргийг давхар гүйцэтгэж байна. Багш нарын хэлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахыг урамшуулах нөхцөл сул, тэгш хамруулах боловсролоор мэргэшсэн хүний нөөц дутагдалтай, нотолгоонд суурилсан сургалтын хөтөлбөр, арга зүй байдаггүй зэрэг нь хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээл байна.

44. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тухай сайд нарын хамтарсан тушаал (2018 оны 11 дүгээр сар)-ыг ХНХЯ, БСШУСЯ болон Эрүүл Мэндийн Яамнаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээнд хамруулах үндсэн үүрэг хүлээсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв болон салбар комиссуудын чиг үүрэг, үйл ажиллагааг тодруулах зорилгоор баталсан. Боловсролын үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх тухай 3.6 дахь хэсэгт тэгш хамруулан сургах орчин бүрдүүлэх, нийтлэг загварын зарчмуудыг

мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг илрүүлэх ба тэдний хэрэгцээг тогтоох зорилго бүхий сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулах болон ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөө боловсруулах асуудлуудыг тусгасан.

45. **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийн тухай үндэсний хөтөлбөр, 2018–2022 он.** Зорилт 2 нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны боловсролд тэгш хамруулахыг онцолсон бол Зорилт 3-ын хүрээнд үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нөхцөл байдлын талаарх судалгаа хийх тухай, Зорилт 4-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах болон эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тодорхойлох тухай заажээ. Гэвч 2019 оны байдлаар комиссын зүгээс аливаа тоон мэдээлэл эсвэл тайлан гаргаагүй байна.

3.2 Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас баталсан зарим журам, бодлогын баримт бичиг

46. **Ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөө (2018 он).** 2018 оны 2 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/155 тоот тушаалаар ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөө (ГСТ)-ний үлгэрчилсэн загварыг баталсан. Сургууль болон гэр бүлийн орчинд хэрэглэгдэхээр боловсруулагдсан ГСТ нь сургалтын төлөвлөгөөг бэлтгэж, багш болон мэргэжилтний зүгээс үзүүлэх мэргэжлийн дэмжлэгийг тодорхойлж, хүүхдийн хөгжлийн өнөөгийн бодит байдалд тулгуурлан дэмжлэгийн тогтолцоог бий болгоно. ГСТ нь хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. ГСТ-г 2018–2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэж байгаа ба одоо сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрд зориулан боловсруулаад байна. Гэвч ГСТ-г тохиромжтой байдлаар боловсруулахад зарим багш нарын хувьд мэдлэг, чадавх, туршлага дутагдаж байна. АХБ-ны асуулга судалгаагаар ердийн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдээс хүүхдийнх нь тусгай хэрэгцээ, онцлог шинж чанарууд дээр тулгуурласан ГСТ байдаг эсэхийг асуухад тэдний талаас илүү (56%) нь үгүй гэж хариулсан. Багш нараас суралцагчийн тусгай хэрэгцээ, онцлог шинжүүд дээр тулгуурлан сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулж болох эсэхийг асуухад 21% нь үгүй, 5% нь мэдэхгүй гэж хариулсан. Багш нарын ойролцоогоор гуравны нэг хувь (30%) нь багаар гүйцэтгэх төслийн үед хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээл болон тусгай хэрэгцээг үргэлж харгалзан үздэг гэсэн бол тал (49%) нь ихэнхдээ харгалзан үздэг, 9% нь ихэнхдээ харгалзан үздэггүй, 12% нь огт харгалзаж үздэггүй гэж хариулсан. Энэ нь багш нарын практик үйл ажиллагаа болон эцэг эхчүүдийн хүлээлт хоёрын хооронд ихээхэн зөрүү байгааг илэрхийлж байна. Багш нарын ердөө 40% нь сурагчид гэрийн даалгавраа хийхдээ багшаас тогтмол дэмжлэг авах боломжтой байдаг гэсэн бол 42% нь боломжгүй, 9% нь ихэнхдээ боломжгүй, 3% нь огт боломжгүй гэж хариулсан.

47. **Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээ (2018 он).** 2018 оны 6 дугаар сард батлагдсан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/425 тоот тушаал 2018–2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжиж байна. Тус журамд хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ГСТ-өөр суралцаж буй суралцагчийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ гэж заасан. Тэрчлэн суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд суурилан шалгалтын комисс шийдвэрлэнэ. Энэ журам нь үнэлгээг суралцагчийн ахиц дээр тулгуурлан хийх явдлыг дэмжсэн уян хатан зохицуулалтыг агуулсан тул тэгш хамруулах боловсролыг дэмжсэн урагшилсан алхам юм. АХБ-ны асуулга судалгаагаар багш нарын 63% нь тэдэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагын амжилтыг үнэлэх системтэй аргачлал дутагддаг гэж хариулсан. Үнэлгээг уян хатан хийх талаарх багш нарын мэдлэг, ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх шаардлагатай. Эцэг эхчүүдийн оролцоо чухал үүрэгтэй байдаг. Судалгааны үр дүнгээс харахад багш нарын 15% нь суралцагчдын гэрийн даалгаврын

гүйцэтгэлийг үнэлэхдээ эцэг эхчүүдийн саналыг үргэлж сонсдог бол 45% нь ихэнхдээ сонсдог, 27% нь ихэнхдээ сонсдоггүй, 13% нь огт сонсдоггүй гэж хариулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оролцоо мөн адил чухал: багш нарын 24% нь суралцагчдад сонирхол, мэдлэгээ хөгжүүлэхийг нь дэмжих гэрийн даалгавар сонгох боломжийг үргэлж олгодог гэсэн бол 59% нь ихэнхдээ олгодог гэж хариулсан.

48. **Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам (2012 он).** Засгийн газрын А/185 тоот тушаалаар батлагдсан журмын 3.2 дахь хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгохдоо нэг суралцагчийн хувьсах зардлын нормативыг гурав дахин нэмэгдүүлж тооцохоор тусгасан. Энэ заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж буй ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарах тухай 3.3 дахь хэсэгт тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, ердийн сургууль, цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд гурав дахин өндөр санхүүжилт авч болно. Гэхдээ энэ журам ердөө 2019 оны хавраас эхлэн хүчин төгөлдөр болсон.

49. **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам (2019 он).** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/292 тоот тушаалаар 2019 оны 5 дугаар сард батлагдсан журам нь хүүхдийг сургуульд тэгш хамран сургахад туслалцаа үзүүлэх дэмжлэгийн багийг байгуулах, хүүхдийн хэрэгцээ, онцлог шинж байдал дээр тулгуурлан тусгай сургуулиуд, эцэг эхчүүдтэй хамтран ажиллах, мөн “хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” буюу нөөц төв байгуулах замаар тэгш хамруулах орчинг бүрдүүлэхийг зорьсон. Эдгээр шинэ үйл ажиллагаатай холбогдох зардлыг сургуулийн жил бүрийн төсөвт тусгахаар заажээ. АХБ-ны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн 34% нь хүүхдүүд нь хичээлээс гадуурх дугуйлан, үйл ажиллагаанд өөрсдөө сонгон оролцох боломжтой гэсэн бол 27% нь боломжгүй гэж хариулсан. Хүүхдүүд нь шаардлагатай үед багш нар болон сургуулийн ажилтнуудаас дэмжлэг авдаг эсэхийг асуухад эцэг эхчүүдийн 27% үгүй, 12% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

50. Энэ хэсэгт авч үзсэн дүгнэлтүүдээс харахад тэгш хамруулах боловсролыг дэмжих тогтолцоо Монгол Улсад хөгжлийн эхний шатандаа байна. Эдгээр мэдээлэл, дүгнэлт нь боловсролын чанар эсвэл боловсролын тэгш хамруулсан байдлын талаар эцэслэн тодорхойлон дүгнэсэн гэсэн үг биш билээ. Эдгээр нь ердөө авч буй арга хэмжээнүүд нь хараахан бүрэн дүүрэн үр дүнтэй биш эсвэл бүрэн хэрэгжээгүй гэдгийг харуулж байгаа юм.

4. МОНГОЛ УЛС ДАХЬ ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ИНДИКАТОРУУДЫГ БОЛОВСРУУЛАХ НЬ

51. Хөгжлийн бэрхшээлтэй монгол хүүхдүүдэд боловсролын орчинд тулгарч буй нийтлэг саад бэрхшээл болон сул талуудыг тодорхойлохын тулд АХБ-ны судалгаагаар Тони Бут, Мел Эйнскау нарын боловсруулсан Тэгш хамралтын индекс буюу тэгш хамруулах боловсролын индикаторуудын хүрэн дээр суурилан эцэг эхчүүд, багш нар, нийгмийн ажилтнуудаас болон ажиглалтаар дамжуулан тоон болон чанарын мэдээлэл цуглуулсан.²⁴ Энэ хүрээ нь тэгш

²⁴ Бут, Т., М. Эйнскау. 2002. *Тэгш хамралтын индекс: Сургууль дээрх суралцахуй болон оролцоог хөгжүүлэх нь*. Нэгдсэн Вант Улс: Тэгш хамруулах боловсролын талаарх судалгааны төв.

хамралт болон үл хамралтыг сургуулийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хоорондоо хамаарал бүхий гурван индикаторын хүрээнд авч үздэг: Тэгш хамруулах соёлыг бий болгох, тэгш хамруулах бодлого боловсруулах, тэгш хамруулах практик үйл ажиллагааг хөгжүүлэх. Судалгааны багийнхан Монгол Улсын нөхцөл байдалтай нийцүүлэн дөрөв дэх буюу тэгш хамруулах материаллаг орчинг бүрдүүлэх гэсэн индикаторыг нэмсэн.

52. Тус судалгаанд тэгш хамруулах боловсролын индикаторуудыг дараах байдлаар тодорхойлон авч үзсэн:

- (i) **Тэгш хамруулах соёл.** Сургууль нь бүх хүүхдийн хувьд аюулгүй, хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд ээлтэй орчин, соёл, үнэт зүйлсийг бий болгосон эсэх. Тэгш хамруулах соёл нь өндөр чанартай суралцах боломжуудыг бий болгох болон хүүхэд бүрийг хүлээн зөвшөөрөгддөг, хүндлэгддэг, үнэлэгддэг гэдгээ мэдрэх боломж олгосон орчныг бүрдүүлэхэд нэн чухал билээ. Энэ индикатор нь сургуульд хамрагддаг хүүхэдтэй эцэг эхчүүдээс асуусан есөн асуулт, цэцэрлэгт явдаг хүүхэдтэй эцэг эхчүүдээс асуусан найман асуултын хариулт дээр суурилсан.
- (ii) **Тэгш хамруулах бодлого.** Сургуулийн дотоод бодлого, журам болон төлөвлөгөөнүүд нь суралцагчдын оролцоог дэмжих, хүүхэд нэг бүрд хүрч үйлчлэх, ялгаварлан гадуурхалтыг хамгийн бага түвшинд хүргэхэд чиглэсэн эсэх. Энэ индикатор нь сургуульд хамрагддаг хүүхэдтэй эцэг эхчүүдээс асуусан зургаан асуулт, цэцэрлэгт явдаг хүүхэдтэй эцэг эхчүүдээс асуусан дөрвөн асуулт, багш нараас бодлогын талаар асуусан асуултуудын хариулт дээр суурилсан.
- (iii) **Тэгш хамруулах практик үйл ажиллагаа.** Сургууль нь тэгш хамралтын зарчмуудыг агуулсан бөгөөд соёлын хүчин зүйлсийг харгалзан үзсэн бодлогын хэрэгжилтийг хэрхэн хангадаг талаар. Энэ индикатор нь сургуульд хамрагддаг хүүхэдтэй эцэг эхчүүдээс асуусан зургаан асуулт, цэцэрлэгт явдаг хүүхэдтэй эцэг эхчүүдээс асуусан таван асуултын хариулт дээр суурилсан.
- (vi) **Тэгш хамруулах материаллаг орчин.** Сургууль нь шаардлагатай үед хэрэг болох нэмэлт тоног төхөөрөмж, материал бүхий дотоод, гадаад хүртээмжтэй орчинтой эсэх. Энэ индикатор нь судалгааны багийнхны хийсэн ажиглалт дээр суурилсан.

53. Тэгш хамруулсан соёл, бодлого, практик гэсэн гурван индикаторын хувьд оноог хүүхдийнх нь хамрагддаг сургууль эсвэл цэцэрлэг тухайн индикаторын хувьд сайн ажилладаг гэж үзэн эерэг хариулт өгсөн эцэг эхчүүдийн хариултын эзлэх хувиар тооцсон. Тэгш хамруулсан материаллаг орчныг үнэлсэн оноог гадаад орчин, дотоод орчин болон анги танхимын орчинд хийсэн хараат бус үнэлгээн дээр суурилан гаргасан.²⁵

²⁵ Дараах хэсгүүд дэх оноог хэрхэн ойлгох вэ: Тэгш хамруулсан хамт олон, тэгш хамруулсан мөн чанар гэсэн дэд индикаторуудын хувьд оноог тооцохдоо асуултад эерэг хариулт өгсөн хүмүүсийн дундаж хувийг, харин тэгш хамруулсан соёлын оноог эдгээр дэд индикаторуудын дундаж оноог ашигласан. Тэгш хамруулсан бодлого, тэгш хамруулсан практик үйл ажиллагааны оноонууд нь асуултад эерэг хариулт өгсөн хүмүүсийн дундаж хувь юм. Тэгш хамруулсан материаллаг орчны индикаторыг аймгаар биш харин сургуулийн хувьд оноогоор үнэлсэн; гурван чиглэл тус бүрийн оноо (гадаад орчин, дотоод орчин, анги танхим) нь шалгах хуудас дээрх зүйлс тухайн байгууллагад байгаа эсэхийг илэрхийлсэн хувь (хувь илүү өндөр байх тусам илүү сайн гэсэн үнэлгээ); нэгдсэн оноо нь эдгээр гурван онооны дундаж юм.

4.1 Тэгш хамруулсан соёл

54. Энэ индикатор нь хүүхдэд ээлтэй соёл болон харилцан хүндлэлийн мөн чанарын түвшинг хэмжих ба сонгогдсон сургууль, цэцэрлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхах байдлыг амжилттай хязгаарладаг эсэхийг үнэлнэ. Тэгш хамруулсан соёлын индикатор нь хоёр дэд бүрэлдэхүүн хэсэгтэй, үүнд:

- (i) **Тэгш хамруулсан хамт олон**
 - (a) хүмүүс хоорондоо эелдгээр болон хүндлэлтэйгээр харьцдаг эсэх
 - (b) багш нар хүүхэд бүрийн онцлог шинж байдал болон тусгай хэрэгцээг харгалзан үзэж хүүхдүүдтэй эелдгээр харьцдаг эсэх
 - (c) сургууль нь суралцах аюулгүй орчноор хангадаг эсэх
 - (d) сургууль нь ялгаварлал, гадуурхалтаас ангид орчин эсэх
 - (e) багш нар болон сургуулийн ажилтнууд хүүхдүүдийг хамтдаа болон багаар ажиллахыг дэмждэг эсэх
- (ii) **Тэгш хамруулсан мөн чанар**
 - (a) багш нар хүүхдүүдтэй адил тэгш бөгөөд ялгаварлалгүй харьцдаг эсэх
 - (b) сургууль нь ёс зүйн өндөр стандарт болон түүнийг хангасан шилдэг багш нартай эсэх
 - (c) сургууль нь хүүхдүүдийг маргаан, зөрчилдөөнийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэхийг хөхиүлэн дэмждэг эсэх
 - (d) багш нар хүүхэд бүрийн өвөрмөц шинж чанарыг хүлээн зөвшөөрч, ийм шинж чанарыг аливаа үйл ажиллагааны туршид харгалзан үздэг эсэх.

55. Сонгогдсон сургууль, цэцэрлэгийн тэгш хамруулсан соёлын оноог Хүснэгт 6-д харуулав. Тэгш хамруулсан соёлын хувьд сургуулиудын авсан дундаж оноо нь 62, цэцэрлэгүүдийнх 52 байна. Эдгээр оноо нь Монгол Улсад хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах соёл хараахан төлөвшөөгүй байгааг харуулж байна. Дундговь аймгийн оноо нь бусад аймаг, дүүргийн онооноос арай өндөр байна.

Хүснэгт 6: Тэгш хамруулсан соёлын оноо

	Дорнод	Дархан-Уул	Дундговь	Хөвсгөл	УБ	Дундаж
Сургуулийн тэгш хамруулсан хамт олон	59	59	75	60	63	63
Сургуулийн тэгш хамруулсан мөн чанар	59	66	66	54	62	62
Сургуулийн тэгш хамруулсан соёл ерөнхий байдлаар	59	63	71	57	63	62
Цэцэрлэгийн тэгш хамруулсан хамт олон	43	58	69	67	46	56
Цэцэрлэгийн тэгш хамруулсан мөн чанар	37	46	56	50	44	47
Цэцэрлэгийн тэгш хамруулсан соёл ерөнхий байдлаар	40	52	63	58	45	52

УБ = Улаанбаатар.


Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн тусалцааны зөвлөхийн тайлан. Манила.

56. Тэгш хамруулсан хамт олон болон тэгш хамруулсан мөн чанарын талаарх асуултуудад сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн өгсөн хариултын талаарх мэдээллийг График 5-д харуулав. Байршлаар нь авч үзвэл Дундговь аймгийн сонгогдсон сургуулиуд тэгш хамруулсан соёлын хувьд хамгийн өндөр оноо авсан бол Улаанбаатар хот болон Дархан-Уул аймгийн сонгогдсон сургуулиуд хамгийн доогуур оноо авсан байна. Хүүхдүүд сургуулийн орчинд бүх төрлийн ялгаварлал гадуурхалтаас ангид байдаг эсэх тухай асуулт нь хамгийн бага оноогоор үнэлэгдсэн байна.


57. Эцэг эхчүүд олон асуултанд ихэнхдээ “Мэдэхгүй” гэж хариулсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь эцэг эхчүүд сургуулийн талаар болон сурагчдын дундах зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэдэг зэрэг багшийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар мэддэггүй гэсэн үг билээ.

58. Цэцэрлэгийн тэгш хамруулсан соёлын хувьд сургуулийн орчныг хэмжсэнтэй адил арга ашигласан (График 6). Сонгогдсон аймаг, дүүргүүдэд 2–5 настай үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагч болох 110 хүнээс асуулгаар мэдээлэл цуглуулсан. Байршлаар нь авч үзвэл Хөвсгөл, Дундговь аймгуудын сонгогдсон цэцэрлэгүүд хамгийн өндөр оноо авсан бол Улаанбаатар хот, Дорнод аймгийн сонгогдсон цэцэрлэгүүд харьцангуй доогуур үнэлэгдсэн. Хамгийн бага оноогоор үнэлэгдсэн индикатор нь хүүхдүүд цэцэрлэгийн орчинд бүх төрлийн ялгаварлал гадуурхалтаас ангид байдаг эсэх тухай асуулт байна. Энэ индикаторын хувьд сургуулиуд цэцэрлэгүүдээс нэлээд доогуур үнэлэгдсэн боловч бусад индикаторын хувьд нэлээд дээгүүр үнэлгээтэй байгаа нь сонирхол татаж байна. Тэгш хамруулсан мөн чанарын талаарх ихэнх индикаторын үнэлгээ мөн доогуур байна. Хамгийн доогуур үнэлгээтэй индикатор нь багш нар хүүхэд бүрийн өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч, түүнийг нь сургалтын үйл ажиллагаандаа анхаарч үздэг эсэх явдал байна.

График 5: Сургууль дээрх тэгш хамруулсан соёл




Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн тусалцааны зөвлөхийн тайлан. Манила.



59. Судалгааны хүрээнд эцэг эхчүүдээс төрөл бүрийн нэмэлт асуулт асуусан.²⁶ Тэдний хариулт сургуулийн орчинд ялгаварлан гадуурхах явдал түгээмэл тохиолддог ба багш нар хүүхдүүдийн тусгай хэрэгцээг, ялангуяа хэл ярианы бэрхшээлтэй, өөртөө итгэлтэй биш, өөрчлөлтөд дасан зохицохдоо удаан болон/эсвэл юм тогтоохдоо удаан хүүхдүүдийн онцлог хэрэгцээг хичээл заахдаа харгалзан үздэггүй гэдгийг илтгэж байна. Ердийн сургуульд үе тэнгийнхнийхээ хамт амжилттай суралцаж байгаа үйлдлийн чадварын бэрхшээлтэй олон хүүхэд байна. Гэвч ярилцлагаар багш нар заримдаа үйлдлийн чадварын бэрхшээлтэй хүүхдүүдийг үл хайхардаг, ялгаварладаг, эсвэл тэднээс залхдаг гэдэг нь тогтоогдсон. Үйлдлийн чадварын бэрхшээлтэй хүүхэдтэй, судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 5–7% нь

²⁶ Судалгааны үр дүнг бүтнээр нь дараах тайлангаас харна уу: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

хүүхдүүд нь сургууль дээрээ найз нөхөдгүй бөгөөд сургуульдаа явах дургүй гэж хариулсан. Аюулгүй байдлын талаарх эцэг эхчүүдийн илэрхийлсэн үзэл бодлоос анхаарал татсан нэг зүйл байгаа нь (График 7) сургуулийн насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн гуравны нэг (34%) нь, цэцэрлэгт хамрагддаг хүүхэдтэй эцэг эхчүүдийн 21% нь хүүхдүүд нь сургууль, цэцэрлэг дээрээ бүрэн дүүрэн аюулгүй орчинд байдаг гэж үздэггүй явдал юм.



60. АХБ-ны судалгааны үр дүнгээс харахад сургуулиудын хувьд тэгш хамруулсан соёлыг бий болгохын тулд нэлээд олон ажил хийх шаардлагатай байгаа ч цэцэрлэгүүдийн хувьд ийм соёл хөгжиж эхэлж байна. Эцэг эхчүүдийн хариултаас харахад Дундговь аймгийн цэцэрлэг, сургуулиуд бусад аймгуудынхтай харьцуулахад илүү тэгш хамруулсан соёлтой байна. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлийн хувьд харааны, сонсголын, хөдөлгөөний, хэл ярианы бэрхшээлтэй зэрэг бие эрхтэний саад бэрхшээлтэй хүүхдүүд болон соёлын өвөрмөц хэрэгцээтэй хүүхдүүд цэцэрлэгийн орчинд олон бэрхшээлтэй тулгардаг байна. Үүний зэрэгцээ сургуулийн насны хүүхдүүд найз нөхөдтэй болох, харилцан яриа үүсгэх, суралцах, юм цээжлэх зэрэг таних мэдэхүйн болон харилцааны ур чадварын хувьд илүү их бэрхшээлтэй тулгардаг гэж зарим эцэг эх үзжээ. Сургууль, цэцэрлэгийн аль алинд нь хүүхдүүдийн гадаад төрх байдал, хөгжлийн бэрхшээл, өвөрмөц шинж байдлаас болоод ялгаварлан гадуурхах хандлага тохиолддог гэж олон хүн хариулсан. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд хүүхдүүдийн тусгай хэрэгцээг сургалтын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн анхаарч үздэггүй гэдгийг онцолсон (Шигтгээ 2).

Шигтгээ 2: Багш нар таны хүүхэдтэй хэрхэн ажилладаг вэ?

Манай хүүхдийн багш нар анги нийтэд нь хичээл заахаас биш хүүхэдтэй ганцаарчлан ажиллах нь ховор байдаг. Биеийн тамирын багш нь миний охины нөхцөл байдлыг мэдэх тул түүнтэй өөрөөр харьцдаг. Тооны багш нь надад “Танай хүүхэд яагаад юу ч сурч чаддаггүй юм бэ, та өөрөө хүүхдэдээ заах хэрэгтэй, эсвэл охиноо тусгай сургуульд явуул” гэж хэлсэн. Би багш нартай нь ярилцаж үзсэн, хэн нь ч эерэг зүйл хэлж байгаагүй. Тэд охинд минь хичээл заах эсвэл түүнээс шалгалт авах хэцүү гэдгийг хэлдэг. Би тооны багшаас “Манай хүүхэд бүх тоог бодож чадахгүй бол түүний хийж чадах дасгалуудыг үнэлж болохгүй юу?” гэж асуусан. Багш, тэр шалгалт хичээлийн жилийн эцсийн шалгалт байсан тул болохгүй гээд манай охиныг юм сурах ёстой гэсэн.

Эх сурвалж: Тархины саажилттай хүүхдийн ээжтэй хийсэн ярилцлага, Орхон аймаг, 2019 оны 8 дугаар сарын 3.

4.2 Тэгш хамруулсан бодлого


61. Сургууль, цэцэрлэгийн аль алинд хамаарах тэгш хамруулсан бодлогыг тодорхойлсон индикаторыг Хүснэгт 7-д харуулав.

Хүснэгт 7: Тэгш хамруулсан бодлогын оноо

	Дорнод	Дархан-Уул	Дундговь	Хөвсгөл	Улаанбаатар	Дундаж
Сургуулийн тэгш хамруулсан бодлого	59	58	65	63	65	62
Цэцэрлэгийн тэгш хамруулсан бодлого	38	44	59	42	42	45

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

62. График 8-д тэгш хамруулсан бодлогын оноог тооцон харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг харуулав. Энэ нь сургууль, цэцэрлэг дэх тэгш хамруулсан бодлогын талаарх эцэг эхчүүдийн үзэл бодол юм. Бодлогын орчныг цэцэрлэгийн насны хүүхэдтэй эцэг эхчүүд дөрвөн индикатораар, сургуулийн насны хүүхэдтэй эцэг эхчүүд зургаан индикатораар үнэлсэн. Багш нар мөн адил тэгш хамруулсан бодлогын орчныг үнэлсэн бөгөөд тэдний хариулт нь эцэг эхчүүдийнхээс нэлээд эерэг байсан. Энэ нь эцэг эхчүүд болон багш нарын үзэл бодол зөрүүтэй байгааг илтгэж байна. Үүнийг шийдвэрлэхээс нааш тэгш хамруулсан бодлогын хувьд эцэг эхчүүдийн санааг хамгийн их зовоож буй асуудлуудад багш нар анхаарлаа хандуулахгүй байж болзошгүй юм.



63. Сургалтын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахын тулд сургуулийн зүгээс бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах болон сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад тохируулах, нийцүүлэх явдал сул байна. Энэ байдал ялангуяа хэл ярианы болон ой тогтоолтын хувьд хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд илүү ярвигтай байна (ХБСХ 2019).

64. Дүгнэн хэлэхэд, хууль эрх зүйн орчин ээлтэй хэдий ч (Бүлэг 3-д тусгагдсан) тэгш хамруулсан бодлогыг үнэлсэн онооноос харахад бодлогын хэрэгжилт хангалттай биш бөгөөд үүнийг цаашид сайжруулах шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгож буй боловсролын үйлчилгээг үр дүнтэй байлгахын тулд сургуулиуд нь мэргэжлийн байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон тэгш хамруулах боловсролыг дэмждэг бусад талуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, тэднийг төлөвлөлт хийх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох явдлыг баталгаажуулах хэрэгтэй.

4.3 Тэгш хамруулсан практик үйл ажиллагаа

65. АХБ-ны судалгаа нь практик үйл ажиллагааны тэгш хамруулсан байдалд үнэлгээ өгөх замаар сургууль, цэцэрлэгүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш оролцоог хангаж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон. Хүснэгт 8-д сургууль, цэцэрлэгүүдийн практик үйл ажиллагааны тэгш хамруулсан байдалд сургуулийн хувьд зургаан индикатор, цэцэрлэгийн хувьд таван индикаторын хүрээнд эцэг эхчүүдийн өгсөн оноог нэгтгэсэн байдлаар харуулав.

Хүснэгт 8: Тэгш хамруулсан практик үйл ажиллагааны оноо

	Дорнод	Дархан-Уул	Дундговь	Хөвсгөл	Улаанбаатар	Дундаж
Сургуулиудын тэгш хамруулсан практик үйл ажиллагаа	56	49	67	39	54	53
Цэцэрлэгүүдийн тэгш хамруулсан практик үйл ажиллагаа	22	39	50	27	31	34

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн тусалцааны зөвлөхийн тайлан. Манила.


66. Судалгааны үр дүнгээс харахад тэгш хамруулсан практик үйл ажиллагааны хувьд цэцэрлэгүүд харьцангуй доогуур буюу 34 оноогоор үнэлэгдсэн байна. Олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх болон хүүхдүүдэд бусдын ялгаатай байдлыг хэрхэн хүндлэхийг зааж сургах талаарх цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа хангалтгүй байна. Цэцэрлэгүүд мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ялгаатай хэрэгцээг хангахын тулд нэмэлт үйлчилгээ үзүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна. Энэ асуудал нь ялангуяа хараа, сонсгол, тулгуур хөдөлгөөний болон том, жижиг булчингийн хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд илүү тулгарч байна. Сургуулиуд арай өндөр буюу 53 оноогоор үнэлэгдсэн ба хүүхдүүдэд сургууль дээрх олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэхийг зааж сургах талаар цэцэрлэгүүдтэй адил түвшинд байна. Цаашлаад сургуулиуд нь суралцахуйн үр дүнг сайжруулахын тулд тэгш хамруулах боловсролыг дэмжигч талуудтай хамтран ажиллах тал дээр сул байна (дэлгэрэнгүйг График 9-өөс харна уу). Дундговь аймаг хамгийн өндөр гүйцэтгэлтэй байна.

67. Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, суралцахуйн ба ойн тогтоолтын хувьд хүндрэл бэрхшээлтэй болон анхаарал төвлөрөлтийн асуудалтай хүүхдүүдийн эцэг эхчүүд сургуулийн орчинд тэгш хамруулах боловсролын хувьд ихэвчлэн асуудалтай тулгардаг байна. Тэгш хамруулах орчинг бүрдүүлэхийн тулд сургуулиуд эдгээр асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Ерөнхийдөө судалгааны үр дүн боловсролын байгууллагуудын орчин тэгш хамруулсан байдлын хувьд хангалтгүй байгааг харуулж байна. Ердийн цэцэрлэг, сургуулиудад үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүд хамрагдах нь нэмэгдэж байгаа ч боловсролын байгууллагуудын орчин нь тэгш хамруулах стандартуудад нийцэхгүй хэвээр байна. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээнд нийцүүлэхийн тулд сургуулийн сургалтын хөтөлбөрүүд, заах арга зүй болон багш нарыг сургах арга зүйд тохируулга, шинэчлэл яаралтай хийх хэрэгтэй.

68. Судалгааны үр дүнгээс харахад цэцэрлэгүүд хараа, сонсгол болон/эсвэл тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээг зохистой байдлаар хангаж чадахгүй байгаа бол сургуулиуд суралцахуйн болон анхаарал төвлөрүүлэх хүндрэлтэй, ой санамжийн хувьд болон хүмүүстэй харилцахдаа асуудалтай тулгардаг хүүхдүүдийн тусгай хэрэгцээг хангаж чадахгүй байх хандлагатай байна.

69. Судалгааны үр дүнгүүдээс ерөнхийд нь харвал сургууль, цэцэрлэгүүдийг бодлого болон соёлын хувьд арай дээр байгаа ч тэдгээрийн практик үйл ажиллагааны үр дүнг нь хараахан мэдрэхгүй байна гэж эцэг эхчүүд үзэж байна. Энэ нь шинээр баталсан үндэсний хэмжээний бодлого, хууль тогтоомж нь хараахан бүрэн бөгөөд үр дүнтэй хэрэгжихгүй байгааг баталж байна. Бодлого болон санаж төлөвлөсөн зүйлсээ практикт үнэхээр хэрэгжүүлэхийн тулд багш нарыг сургах болон анги танхимд нэмэлт нөөцөөр хангах шаардлагатай гэж дүгнэж болохоор байна. Эдгээр саналыг бусад зөвлөмжийн хамт Бүлэг 5-д нэгтгэн харуулав.

График 9: Тэгш хамруулсан практик үйл ажиллагаа



ХБХ = Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд.

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

4.4 Тэгш хамруулсан материаллаг орчин

70. АХБ-ны судалгаа нь тэгш хамруулсан материаллаг орчныг сонгогдсон аймаг, дүүргийн сургууль, цэцэрлэгүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй, тэдний хэрэгцээнд суурилсан бөгөөд тэдэнд дэмжлэг үзүүлэхүйц сургалтын барилга байгууламж, хэрэгслүүдээр хангагдсан эсэхийг үнэлэхийг зорьсон. Сургуулийн удирдах ажилтнууд, багш нар болон бусад ажилтан зэрэг 76 хүнээс авсан мэдээлэл; 650 гаруй асран хамгаалагч (ээж эсвэл асран хамгаалагч)-тай хийсэн ярилцлага; байх ёстой шинж чанаруудын хяналтын хуудас ашиглан хийсэн сургуулийн орчны ажиглалт дээр суурилан дүн шинжилгээ хийсэн.

71. Тулгарч буй асуудал, бэрхшээлийн хувьд багш нарын 91% нь тэдэнд хичээл заах болон сурагчдад судлах сургалтын материалууд болон шаардлагатай барилга байгууламж, тоног хэрэгсэл хангалтгүй байдаг гэсэн бол 43% нь дэд бүтцийн хүртээмжгүй байдал болон сургуулиудын ерөнхийдөө бэлтгэлгүй байдал нь гол бэрхшээл болж байна гэж үзсэн. Эдгээрээс харахад багш, сурган хүмүүжүүлэгчид хүртээмжтэй барилга байгууламж, тоног хэрэгсэл болон тэдэнд хичээл заах болон сурагчдад зориулсан сургалтын материалын хангамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулах замаар суралцах орчныг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна. Хүснэгт 9-д хяналтын хуудас ашиглан сургалтын барилга байгууламжийн байдалд хийсэн ажиглалтын дүнг нэгтгэн харуулав. Сонгогдсон сургууль, цэцэрлэгүүдийн гадаад, дотоод орчин дахь тоног хэрэгслүүд, материаллаг орчныг ерөнхийд нь авч үзэхэд хоорондоо ихээхэн ялгаатай байна.

Хүснэгт 9: Ажиглалтын хяналтын хуудсаар хийсэн асуулга судалгааны үр дүн
(хяналтын хуудсанд тэмдэглэсэн сургууль, цэцэрлэг дээр байгаа зүйлс %)

		Гадаад орчин	Дотоод орчин	Анги танхим	Материаллаг орчин
Сургууль					
Дундговь	3 дугаар сургууль	50	40	71	54
Дорнод	1 дүгээр сургууль	40	76	43	53
УБ, СХ	42 дугаар сургууль	80	68	0	49
Хөвсгөл	Цагааннуур сумын сургууль	20	32	29	27
Дархан-Уул	12 дугаар сургууль	10	32	71	38
Цэцэрлэг					
Дорнод	8 дугаар цэцэрлэг	50	56	57	54
Дархан-Уул	7 дугаар цэцэрлэг	10	60	100	57
Дундговь	23 дугаар цэцэрлэг	60	40	71	57
УБ, СХ	253 дугаар цэцэрлэг	30	76	0	35

СХ = Сонгинохайрхан, УБ = Улаанбаатар.

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн тусалцааны зөвлөхийн тайлан. Манила.

72. Тэрчлэн, тус судалгаагаар 2018–2019 оны хичээлийн жилд сонгогдсон сургууль, цэцэрлэгүүдэд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжиж буй боловсролыг дэмжих хөтөлбөрүүд, үйл ажиллагаа эсвэл энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын тухай мэдээллийг 18 аймаг, дүүргийн боловсролын мэргэжилтнүүдээс цуглууллаа. Энэ мэдээллийг Хүснэгт 10-т харуулав. Өнгөрсөн хичээлийн жилд хөдөө орон нутгийн боловсролын мэргэжилтнүүд аймаг, дүүргийн

Засаг даргын Тамгын газруудтай хамтран сургалтын материалаар хангах, дэд бүтэц болон сургалтын орчныг засварлах төслүүд хэрэгжүүлжээ. Тэд мөн сурах бичиг, сургалтын материалаар хангах, сургуулийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан байна.

73. Материаллаг орчны хувьд авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нэлээдгүй бэрхшээл тулгарч байна. Тус судалгаагаар сургуулийн орчныг дараах гурван чиглэлээр үнэлсэн: (i) дотоод, гадаад орчин, (ii) материаллаг орчны хүртээмжтэй буюу саадгүй байдал, болон (iii) материаллаг орчныг сайжруулах төслүүд.

74. **Дотоод, гадаад орчин.** 6–17 насны хүүхдүүдийн ээж эсвэл асран хамгаалагч болох 556 хүнээс судалгаа авахад 35% нь хүүхдүүд нь сургуулийн гадаад орчны хувьд саад бэрхшээлтэй тулгарч байдаг гэж хариулсан (График 10). Тодруулбал, 26% нь гэр, сургуулийн хооронд зорчих үед, 12% нь биеийн тамирын хичээлийн тоног хэрэгсэл ашиглах үед, 10% нь сургуулийн хашаагаар орох үед, 6% нь төв хаалгаар орох үед хүүхдүүд нь саад бэрхшээлтэй тулгардаг гэжээ. 2–5 насны хүүхэдтэй ээж эсвэл асран хамгаалагч болох судалгаанд хамрагдсан 101 хүний дөрөвний нэг нь хүүхдүүд нь цэцэрлэгийн гадаад орчинд саад бэрхшээлтэй тулгардаг гэжээ. Үүнийг дэлгэрүүлэн үзвэл 20% нь гэр, цэцэрлэгийн хооронд нийтийн тээврээр явахад, 9% нь тоглоомын талбайд тоглоход, 9% нь цэцэрлэгийн хашаа эсвэл байранд орох үед саад бэрхшээл тохиолддог гэжээ.

Хүснэгт 10: Тэгш хамруулах боловсролын төлөөх талуудын хамтын ажиллагаа
(Үйл ажиллагааны тоо)

Үйл ажиллагааны төрөл	Засаг даргын Тамгын газартай хамтарсан	Олон улсын байгууллага эсвэл ТББ-тай хамтарсан	Цэцэрлэг эсвэл хороотой хамтарсан	Сургууль эсвэл НТБТ-тэй хамтарсан
Үйл ажиллагааны тоо				
Эцэг эхчүүдийн сургалт	4	4	1	6
Багш нарын сургалт	3	6	1	4
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжтэй буюу саадгүй нэвтрүүлэх дэд бүтэц ба засвар	6	6	2	5
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн хангамж	4	8	1	0
Олон нийтэд чиглэсэн боловсролын компани ажлууд	3	8	0	5
Туршлага солилцох хөтөлбөрүүд	1	3	2	4
Сургуулийн дэд бүтцийг сайжруулах төслүүд	4	4	1	1
Ном, сургалтын материалаар хангах төслүүд	3	5	0	1
Байхгүй	0	0	0	0
Үйл ажиллагааны тоо	28	44	8	26

НТБТ = Насан туршийн боловсролын төв, ТББ = төрийн бус байгууллага.

Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.



75. Цэцэрлэг, сургуулийн гадаад орчны ажиглалтаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд туслах хэрэгсэлгүйгээр бие дааж зорчих боломжгүй байна. Аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд хангалтгүй байгаа бөгөөд тэдгээрийг сайжруулах шаардлагатай. Доорх хоёр зургаар тэргэнцэр хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд автобусны зогсоолоос цэцэрлэг хүртэл явах боломжгүйг жишээлэн харуулав. Эхний зургаас цэцэрлэг нь автобусны буудлаас хол бөгөөд цэцэрлэг хүртэл шороон замтай байгааг харж болно. Хоёр дахь зурган дээр [цэцэрлэг хүртэлх] засмал зам нь эвдрэлтэй байгаа нь харагдаж байна. Зургуудыг 2019 оны 7 дугаар сард авсан.



Автобусны буудлаас цэцэрлэг хүрэх замын нөхцөл байдал. Зүүн талын зураг дээр Сонгинохайрхан дүүргийн 253 дугаар цэцэрлэг; баруун талын зураг дээр Дорнод аймгийн 1 дүгээр сургууль (Зургуудыг ХБСХ-ээс авав).

76. Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд мөн адил автобусны буудлаас сургууль, цэцэрлэг хүртэл явахад нэлээдгүй саад бэрхшээл тулгардгийг дараах зургуудаас харж болно.




Явган хүний гарц байхгүй ба зам нь тэгш бус гадаргуутай. Зүүн талын зурагт Сонгинохайрхан дүүргийн 253 дугаар цэцэрлэгийн ойролцоо харааны бэрхшээлтэй хүмүүст саадгүй явахад нь туслах явган хүний гарц байхгүйг харуулав; баруун талын зурагт Дорнод аймгийн 1 дүгээр сургуулийн ойролцоох явган хүнд зориулсан зам тэгш бус гадаргуутай байгааг харуулав (Зургуудыг ХБСХ-ээс авав).

77. Сургууль, цэцэрлэгийн хашааны хаалганы өргөн, замаар саадгүй нэвтрэх байдал, барилга байшингийн орц, гарцны шатны бариул, хаалтууд нь шаардлага хангахгүй байна. Дараах зургууд нь зам, шатны бариул, тэргэнцрээр орж, гарахад зориулсан хамгаалалт байхгүй, хаалганы өргөн нь хангалтгүй жишээнүүдийг харуулж байна.




Саадгүй нэвтрэх боломжгүй орц, гарцууд. Зүүн талын зурагт Сонгинохайрхан дүүргийн 253 дугаар цэцэрлэг; баруун талын зурагт Дорнод аймгийн 3 дугаар сургууль (Зургуудыг ХБСХ-ээс авав).

78. Сургуулийн насны хүүхдүүдийн ээж болон асран хамгаалагчдын дөрөвний нэгээс илүү хувь нь хүүхдүүд нь сургуулийн дотоод орчинд саад бэрхшээлтэй тулгарч байдаг гэжээ. Үүнд, 14.9% нь бие засах өрөө ашиглах, 12.1% нь номын санд орох, 7.7% нь шатаар явахтай холбоотой асуудлууд байна. Бага насны хүүхдүүдийн ээж нар болон асран хамгаалагчдын 5.9% нь хүүхдүүд нь цэцэрлэгийн дотоод орчинд саад бэрхшээлтэй тулгардаг гэснээс 5% нь шатаар явахад, 3% нь бие засах өрөө ашиглахад бэрхшээлтэй байдаг гэжээ. Ерөнхийд нь үзвэл сургуулийн насны хүүхдүүдийн ээж, асран хамгаалагчдын 15%, бага насны хүүхдүүдийн ээж, асран хамгаалагчдын 5% нь сургууль, цэцэрлэгүүдийн гадаад, дотоод орчны аль алинд нь хүүхдүүд нь саад бэрхшээлтэй тулгарч байдаг гэжээ.



79. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургууль дотор болон анги танхимд бие дааж чөлөөтэй явах боломжийг хангахад сургуулийн дотоод орчин хангалттай хэмжээнд аюулгүй эсвэл хүртээмжтэй биш байна. Дараах зургуудад шатны нэг тал нь хашлагатай эсвэл огт хашлагагүй, шал болон шатнууд нь халтирахаас болгоомжилсон дэвсгэр наалтгүй нэг сургуулийн төрхийг жишээ болгож харуулав. Ариун цэврийн өрөөнүүдийг багш, ажилтнууд эсвэл бусад хүүхдийн тусламжгүйгээр ашиглах боломжгүй байна.




Сургууль, цэцэрлэгийн дотоод орчны нөхцөл байдал. Эдгээр зурагт Дорнод аймгийн 1 дүгээр сургуулийн зарим хэсэг нь аюулгүй эсвэл хүртээмжтэй байдлын үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хангалтгүй байгааг харуулав (Зургуудыг ХБСХ-ээс авав).

80. Ээж болон асран хамгаалагчид материаллаг орчны хувьд сайжруулах шаардлагатай хэд хэдэн зүйлс байгаагийн ихэнх нь дан ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байтугай бүхий л хүүхдийн хувьд саад учруулдаг гэжээ, үүнд:

- (i) нэг ангид хэт олон хүүхэдтэй,
- (ii) сургуулийн автобусгүй,
- (iii) тэргэнцэртэй зорчих зам байдаггүй,
- (iv) бие засах газар зөвхөн гадаа байдаг (Дорнод аймаг),
- (v) хэт олон хүүхэдтэй ч анги танхим нь жижиг бөгөөд халаалтын систем нь доголдолтой (Хөвсгөл аймаг),
- (vi) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сурах бичиг, сургалтын материалууд хангалтгүй.

81. **Материаллаг орчны хүртээмжтэй байдал.** Сургуулийн насны хүүхдүүдийн асран хамгаалагчдын ердөө 57% нь сургуулиуд хангалттай сурах бичигтэй гэж үзсэн боловч 83% нь хүүхдүүд нь сургалтын материалаа бүрэн ашигладаг гэжээ. Сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх орон зай буюу мэргэжлийн сэтгэлзүйн зөвлөгөө өгөх зөвлөхүүд хангалттай биш: Асран хамгаалагчдын ердөө 6% нь хүнд хэцүү үед хүүхдүүдэд тайвшрахад нь туслах сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх өрөө байдаг гэсэн бол ердөө 3% нь хүүхдийн сэтгэл хөдлөлд анхаарал хандуулж, түүнтэй ярилцах зэргээр сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг багш нар байдаг гэжээ.



82. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэхүй, оюун ухаан, нийгэм болон харилцааны хэрэгцээг хангах сургалтын материал, ном, сурах бичиг мөн хангалтгүй байна. Нэгэн ээжийн үзэл бодлыг Шигтгээ 3-т харуулав. Тэрчлэн шаардлагатай эрэлт хэрэгцээг хангах дэмжлэгт үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйч, хэл засалч, физик эмчилгээний эмч, дохионы хэлний багш зэрэг мэргэжилтэн хангалттай биш.

Шигтгээ 3: Тусгай хэрэгцээнд үзүүлэх сургууль дээрх дэмжлэг


Тоног төхөөрөмж, сурах бичгүүд байдаггүй ба хамгийн гол нь мэргэжлийн сэтгэл зүйч байдаггүй. Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сурах бичиг, сургалтын материал, тоног төхөөрөмж болон бусад зүйлс байдаггүй нь бидний [ээж, хүү хоёр] хувьд тулгарч буй хамгийн том бэрхшээл юм. Хүүгийн минь хувьд мэдрэхүйгээ ашиглан тоглох тоглоомууд байдаг бол илүү дээр байхсан. Хүрч мэдрэх мэдрэхүйгээ хөгжүүлэхийн тулд хурууны үзүүрээрээ тоглох тоглоом байдаг гэсэн. Би судалж үзсэн боловч манай суманд байдаггүй юм билээ. Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тоног төхөөрөмж, тоглоом маш их дутагддаг.

Эх сурвалж: Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй нэгэн ээжтэй хийсэн ярилцлага, Дундговь аймаг, 2019 оны 7 дугаар сарын 6.

83. **Материаллаг орчныг сайжруулах төслүүд.** Өнгөрсөн жил харьцангуй цөөн сургууль орчноо сайжруулсан байна: Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ойролцоогоор гуравны нэг нь сургуулиас ямар засвар хийх шаардлагатай талаар санал бодлыг нь асууж байсан гэсэн

боловч сургуулийн насны хүүхдүүдийн асран хамгаалагчдын ердөө 17% нь сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан дотор эсвэл гадна орчноо засварласан гэж мэдээлсэн (График 13). Цэцэрлэгүүд гадаад, дотоод орчноо сайжруулах чиглэлээр илүү хүчин чармайлт гаргажээ: Бага насны хүүхэдтэй асран хамгаалагчдын 40% нь өнгөрсөн жил гадаад, дотоод орчны аль алинд нь засвар хийгдсэн гэсэн ба 30% гаруй нь ямар засвар хийх талаар саналаа өгсөн гэжээ.


График 13: Сургууль, цэцэрлэгийн орчны хүртээмжтэй байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, эцэг эхчүүдийн мэдээлснээр



Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

84. Сургуулийн насны хүүхэдтэй, судалгаанд хамрагдсан хүмүүсийн тал нь сургуулийн гадаад, дотоод орчин аюулгүй гэсэн бол 38% нь аюултай гэжээ (График 14). Харин багш нараас анги танхимын хүртээмжтэй буюу саадгүй байдлын талаар асуухад 75% нь эерэг хариулт өгчээ (График 15).

График 14: Дотоод, гадаад орчны аюулгүй байдлын талаарх эцэг эхчүүдийн үзэл бодол (N = 556)



Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкинд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

График 15: Анги танхимын хүртээмжтэй байдлын талаарх багш нарын үзэл бодол
(N = 76)



Эх сурвалж: ХБСХ. 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

85. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын чанарыг сайжруулах болон материаллаг орчны тэгш хамруулсан байдлыг баталгаажуулахын тулд сургуулийн дэд бүтэц, сургалтын материалыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй:

- (i) аюулгүй, эрүүл бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан орчин;
- (ii) анги танхимын талбайн хэмжээ болон нэг ангид суралцах хүүхдийн тоонд стандарт мөрдөх;
- (iii) гэр, сургуулийн хооронд үйлчлэх чанартай, аюулгүй тээврийн үйлчилгээ;
- (iv) үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлийн төрлүүдийг харгалзан үзэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог хэрэгцээг хангах сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх;
- (v) тэгш хамруулан суралцах материаллаг орчныг сайжруулахад хүүхдүүд, эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх;
- (vi) сургалтын материал, тоног төхөөрөмж, дэмжлэгийг сайжруулах, нэмэгдүүлэх;
- (vii) биеийн тамирын хичээлийн заал, талбай, тоглоомын талбай, ариун цэврийн өрөөнүүдийн хүртээмжтэй буюу саадгүй байдлыг сайжруулах.

5. ДҮГНЭЛТ БА МОНГОЛ УЛСАД ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖҮҮД

86. Энэхүү судалгааны хүрээнд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар дээр суурилан хүүхдийн үйлдлийн чадварын модулийг ашиглаж чанартай боловсрол эзэмших боломжгүй байх эрсдэлд байгаа үйлдлийн чадварын бэрхшээлтэй монгол хүүхдүүдийг оношилгоонд хамруулсан. Үйлдлийн чадвар гэдэг нь нийгмийн, материаллаг, эдийн засгийн, мэдээллийн болон орчны бусад саад бэрхшээлтэй харьцах зэргээр хүүхдүүдийн хувьд нийгмийн амьдралд тэгш оролцох явдалд шууд нөлөөлж болох өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг төдийгүй тэднийг боловсрол болон хамт олны харилцаанд бүрэн дүүрэн оролцох явдлыг нь ихээхэн хязгаарлаж байдаг суурь чадварууд юм. Судалгаагаар нийт 5,328 өрхийн 2–17 настай 9,555 хүүхдийг оношилгоонд хамруулсан ба тэдний 9.1% нь үйлдлийн чадварын ямар нэгэн хүндрэлтэй гэдэг нь тогтоогдсон.

87. Судалгаагаар Монгол Улсын нөхцөл байдалд тохирох тэгш хамралтын индикаторуудыг дараах дөрвөн чиглэлээр боловсрууллаа: Тэгш хамруулсан соёл, бодлого, практик үйл ажиллагаа, материаллаг орчин.

- (i) **Тэгш хамруулсан соёл.** Хүүхдүүдийн тусгай хэрэгцээ, олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх, ээлтэй орчин бүрдүүлэх болон тэгш хамралтын мөн чанарыг бодлогод тусган, түүнийг практикт хэрэгжүүлэх явдал сонгогдсон цэцэрлэг, сургуулиуд дээр хангалтгүй байна. Хараа, сонсгол, хэл ярианы болон тулгуур хөдөлгөөний бэрхшээл зэрэг бие эрхтэний бэрхшээлтэй хүүхдүүд цэцэрлэгийн хэвшсэн соёлын орчны улмаас илүү их сөрөг нөлөөлөлд байдаг байна. Харин сургуулийн насны хүүхдүүд найз нөхөдтэй болох, бусадтай яриа өрнүүлэх, суралцах, эргэн санах зэрэг танин мэдэхүй болон харилцааны ур чадварын хувьд бэрхшээлтэй тулгардаг байна. Сургуулийн соёлын орчны хувьд хүүхдүүдийн хувийн мэдээлэл, эд зүйлд хүндэтгэлтэй хандах хандлагын талаар хамгийн олон сөрөг хариулт өгсөн байна.
- (ii) **Тэгш хамруулсан бодлого.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт бага, харин сургуульд хамрагдалт харьцангуй өндөр байна. Гэвч цэцэрлэг, сургуулиудын аль аль нь хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд зориулан нэмэлт сургалт зохион байгуулах, нийцүүлэн өөрчлөх, эсвэл дэмжих талаар уян хатан арга хэмжээ авахгүй байна. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдтэй үр дүнтэй ажиллахын тулд мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах цэцэрлэг, сургуулиудын чадавх ерөнхийдөө хангалтгүй байна.
- (iii) **Тэгш хамруулсан практик үйл ажиллагаа.** Олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх явдлыг хөхиүлэн дэмжих, хүүхдүүдэд бусад хүмүүсийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандахыг зааж сургах чиглэлээрх тэгш хамруулсан практик үйл ажиллагаа үр дүнгүй байгааг илрүүллээ. Энэ чиглэлээрх сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа сул байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн төрөл бүрийн хэрэгцээг хангах нэмэлт үйл ажиллагаа хэрэгжүүлдэг агентлагуудын гүйцэтгэл тааруу байна. Цэцэрлэг, сургуулийн тэгш хамруулах байдал хангалтгүй байгаагийн зэрэгцээ зохистой бодлого, соёл, материаллаг орчны хүртээмжгүй байдлын улмаас үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд суралцах боломж нэмэгдэхгүй байна.
- (iv) **Тэгш хамруулсан материаллаг орчин.** Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд гэр, сургуулийн хооронд нийтийн тээврээр зорчих нь гадна орчин дахь хамгийн том бэрхшээл гэжээ. Сургуулийн дотоод орчин дахь хамгийн түгээмэл бэрхшээл нь ариун цэврийн өрөө ашиглах ба анги танхим дахь гол бэрхшээл нь сургалтын материал, тусгай хэрэгслүүд нь тохиромжгүй байдагтай холбоотой гэжээ.

88. Тэгш хамруулах боловсролын бодлогын хэрэгжилт эхний шатандаа байгаа тул Монгол Улсын тэгш хамруулан сургах орчинтой холбоотой бүх гол индикаторууд хангалтгүй гэж үнэлэгдсэн нь гайхах зүйл биш боловч олон айн хувьд бодлого болон соёлыг эцэг эхчүүдийн зүгээс эергээр үнэлснийг тэмдэглэх хэрэгтэй. Зөвхөн ялгаварлан гадуурхалтын хувьд бодит ахиц хараахан гараагүй байна (эцэг эхчүүдийн үзэж буйгаар). Бодлого болон соёлтой холбоотой асуудлуудыг анги танхим дахь сайн практик болгон хэрэгжүүлэхэд илүү ихийг хийх шаардлагатай байна. Монгол Улсын бодлого, эрх зүйн орчин нь тэгш хамруулах боловсролыг дэмжих чиглэлээр нэлээд ахиц дэвшилтэй байгаа ч бодлого, журмыг бүрэн хэрэгжүүлэхэд санхүү болон хүний нөөц шаардлагатай байна. Боловсролын салбарын төрөл бүрийн оролцогч талууд тэгш хамруулах боловсролын утга агуулга болон түүнд тавигдах шаардлагуудын талаар ялгаатай ойлголттой байгаа талаарх баримт нотолгоо мөн байна. Энэ байдал нь Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг соёл, бодлого, практик,

материаллаг орчны хувьд үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болж байна. Судалгаанаас гарсан гол дүгнэлтүүд дээр суурилан боловсруулсан тодорхой зөвлөмжүүд бүхий дэлгэрэнгүй матрицыг Хүснэгт 11-т харуулав. Зөвлөмжүүдийг дараах хоёр төрлөөр ангилав: Хөгжлийн түншүүдийн хөтөлбөр, төслүүдэд чиглэсэн, засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн.

89. Энд танилцуулсан асуулга судалгааны үр дүн болон зөвлөмжүүд дээр тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ хамт ердийн цэцэрлэг, сургуульд суралцах замаар суралцахуй болон нийгэм-сэтгэл зүйн аль алиных нь хувьд үр шим хүртэх эрхтэй гэсэн үзлийн дор БСШУСЯ-аас (2020 оны 7 дугаар сараас эхлэн Боловсрол, Шинжлэх Ухааны Яам болсон) хэрэгжүүлэх Тэгш хамруулах боловсролыг дэмжих АХБ-ны буцалтгүй тусламжийн шинэ төслийн бүтэц агуулгыг боловсруулсан. 2020 оны 7 дугаар сард батлагдсан Ядуурлыг бууруулах Японы сангаас санхүүжүүлж буй 2 сая ам.долларын буцалтгүй тусламжийн төсөл нь сонгогдсон сургууль, цэцэрлэгүүд дээр саадгүй буюу хүртээмжтэй байдлыг сайжруулах; багш, менежер, орон нутгийн удирдах ажилтнуудын тэгш хамруулсан боловсролын үйлчилгээг хүргэх чадавхыг бэхжүүлэх; тэгш хамруулах боловсролыг дэмжих нөөц, олон нийтийн оролцоо болон бодлогыг эрчимжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ердийн сургууль, цэцэрлэгийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилготой.²⁷ Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих тус буцалтгүй тусламжийн төслийн олон үйл ажиллагааг энд танилцуулах тодорхой зөвлөмжүүд дээр тулгуурлан боловсруулсан болно.

90. Энэхүү төсөл нь ядуу иргэдийг дэмжсэн, нийгэм дэх тэгш хамралт руу чиглэсэн, хүйсийн мэдрэмжтэй байдлыг анхааран үзсэн шинж чанаруудтай. Төслийн үр шимийг хүртэгч үндсэн бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийнхэн—ялангуяа гол асран хамгаалагч болох эмэгтэйчүүд боловч—тэгш хамруулсан боловсрол нь тэрчлэн нийт хүмүүст томоохон ач холбогдол бүхий үр шимийг авчирдаг билээ. Хувь хүний онцлог хэрэгцээг ойлгох, заах арга зүйг үүнд нийцүүлэхийн тулд форматив буюу явцын үнэлгээ ашиглах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг сайжруулахад шаардлагатай олон арга зүй нь тэрчлэн бүхий л суралцагчдад чухал ач холбогдолтой. Цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн анги танхимд тэгш хамруулан сургах нь тэгш хамралт болон дэлхийн иргэн байх талаарх хэлэлцүүлэгт бүх хүүхдийг илүү ерөнхий байдлаар оролцуулах боломж билээ.

²⁷ АХБ. 2020. *Монгол Улс: Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл*. Манила.

Хүснэгт 11: Засгийн газар болон хөгжлийн түншүүдэд хандсан зөвлөмжийн матриц

Дд.	СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ	
		Хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд чиглэсэн	Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн
Ерөнхий зүйл			
1	Бага насны хүүхдүүд (2–5 нас)-ийн хувьд заримдаа үнэлэх болон илрүүлэн тодорхойлоход хэцүү төрөл бүрийн үйлдлийн чадварын хүндрэл, онцлог хэрэгцээ байдаг.	<ul style="list-style-type: none"> • Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй бага насны хүүхдийн онцлог хэрэгцээг тодорхойлох олон улсын үнэлгээний арга зүйг судлах. • Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай нэмэлт дэмжлэгийг тодорхойлох үүрэг бүхий сургуулийн дэмжлэгийн багийг цэцэрлэг дээр туршин ажиллуулах. • Үйлдлийн тодорхой чадваруудын хүндрэлтэй бага насны хүүхдүүдтэй илүү үр дүнтэй ажиллах ур чадварыг нь нэмэгдүүлэхийн тулд цэцэрлэгийн багш нарыг сургах. 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн төв болон салбар комиссын гишүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах, үе шаттай зөвлөгөө өгөн ажиллах. • Тэгш хамруулах боловсролыг дэмжихийн тулд сургууль, цэцэрлэгийн өнөөгийн санхүүжилтийг нэмэгдүүлэх журмыг хэрэгжүүлэх. • Сургуулийн өмнөх боловсролын багш, туслах багш нарын боловсрол, сургалтын (багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх) хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд тэгш хамруулах тухай ойлголт, мэдлэгийг нэвтрүүлэх.
2	Сургуулийн насны хүүхдүүд (6–17 нас)-ийн хувьд хараа, сонсгол, тулгуур хөдөлгөөний бэрхшээл зэрэг таньж мэдэхэд амархан мэдэгдэх үйлдлийн чадварын хүндрэлүүдээс гадна танин мэдэхүйн хүндрэлүүд, сэтгэл түгших, сэтгэлээр унах зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд зэрэг үйлдлийн чадварын “үл харагдах” бэрхшээлүүд нь чанартай боловсролын үйлчилгээнд хамрагдахад томоохон саад бэрхшээл болдог.	<ul style="list-style-type: none"> • Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүд Боловсролын салбарын мэдээллийн системд зохистой байдлаар бүртгэгдэж буй эсэхийг үнэлэх. • Суралцагчдын үнэлгээ хийх сургуулийн дэмжлэгийн багийг байгуулах, ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөнд хяналт тавих. • Сургуулийн дэмжлэгийн багийнхны үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл заах чадавхыг алхам алхмаар сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх. • Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог үе тэнгийнхний дэмжлэг, олон нийтийн хүрч үйлчлэх хөтөлбөрүүдээр дамжуулан нэмэгдүүлэх ажлыг дэмжих. 	<ul style="list-style-type: none"> • Боловсролын салбарын мэдээллийн систем дэх үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн бүртгэлийг илүү сайжруулах, Үйлдлийн чадварын талаарх олон улсын ангиллын системийг нэвтрүүлэх эсвэл үүнийг суралцахуйн хэрэгцээг үнэлэх аргын нэг хэсэг байдлаар эхний ээлжинд тохируулан ашиглах. • Дээрх үйл ажиллагаатай уялдуулан багш нар болон сургалтын менежерүүдэд зориулан сургалт зохион байгуулах хэрэгтэй. Боловсрол, сургалтын зорилго бүхий үнэлгээний систем дэх аливаа өөрчлөлт нь эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ хийхэд ашиглагддаг илүү өргөн хүрээний механизмуудтай нийцтэй байх хэрэгтэй. Нэгдмэл системийг боловсруулахдаа нэг ижил үзэл баримтлал болон үнэлгээний хүрээн дээр суурилах хэрэгтэй.

Хүснэгт 11: Үргэлжлэл

Дд.	СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ	
		Хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд чиглэсэн	Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн
3	Тохируулгат хэрэглэгдэхүүн ба технологи, физик эмчилгээ, хөдөлмөр засал болон хэл заслын үйлчилгээний хүртээмж сул.	<ul style="list-style-type: none"> Сэтгэл зүйн дэмжлэг, хэл засал, физик эмчилгээ, хөдөлмөр заслын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг дэмжих. Тэргэнцэр, сонсголын аппарат, нүдний шил, компьютерын тусламжтайгаар хэл ярианы хөгжлийг дэмжих хэрэглэгдэхүүн зэрэг тохируулгат хэрэглэгдэхүүн, технологиор хангах. 	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүдийг шаардлагатай үйлчилгээнд нь хамруулах боломжоор хангахын тулд эрүүл мэнд, нийгмийн халамжийн системтэй уялдуулах. Хүүхдүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх талаар нийгмийн салбарын ажилтнууд, сургуулийн эмч нарыг чадваржуулах.
Тэгш хамруулсан соёлыг бүрдүүлэх			
4	Хүүхдүүдийн тусгай хэрэгцээ болон олон талт ялгаатай шинж чанаруудыг үргэлж таньж мэдэх боломжгүй, зарим сургуулийн орчин нь хөгжлийн бэрхшээлд ээлгүй бөгөөд бодлого болон практик дахь тэгш хамралтын мөн чанарын хэрэгжилт хангалттай биш. Эцэг эхчүүд ялангуяа хүүхдүүдийнх нь хувьд тулгарч буй ялгаварлан гадуурхалт их байдагт сэтгэл дундуур байна.	<ul style="list-style-type: none"> Бие махбодын олон талт ялгаатай байдлыг (олон талт ялгаатай байдлыг харуулсан тоглоом тоглох, хүүхэлдэйн кино, хүүхэлдэйн театр, хуруу хүүхэлдэй зэргийг ашигласан олон талт ялгаатай байдлын талаарх мессежийг дэмжих) таниулах салбар дундын үйл ажиллагааг нэвтрүүлэх. Танин мэдэхүй, чадвар, харилцаа холбоо болон өөртөө үйлчлэх талаарх хүмүүсийн ялгаатай байдлыг ойлгох боломжийг олгох үйл ажиллагаануудыг зохион байгуулах. Анхдагч болон хоёрдогч олон талт ялгаатай байдлын талаарх ойлголтыг багш нарт танилцуулах, хүүхдүүдийн олон талт ялгаатай байдлыг таньж ойлгох аргуудыг дэмжих болон тэдгээрийг сургалтаар дамжуулан түгээх. Сургуулийн орчинд тэгш хамруулсан соёл, мөн чанартай холбоотой арга хэмжээ зохион байгуулах, тэдгээрийг цэцэрлэг, сургуулиудын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах. Сургуулийн орчинд тэгш байдлын талаарх тэгш хамруулсан соёлыг бий болгохын тулд олон талт бүлгүүдтэй хамтран ажиллах. 	<ul style="list-style-type: none"> Хүмүүсийн олон талт ялгаатай байдлын талаарх сургалтын агуулгыг тодорхойлох болон үүнийг цэцэрлэг, сургуулийн сурах бичгүүдэд хүүхдүүдийн насанд тохирсон байдлаар хэрхэн авч үзэж, мэдээллийг хэрхэн дамжуулах болон хэрхэн тусгахыг тодорхойлох. Сургуулийн сургалтын хөтөлбөрт хүмүүнлэгийн асуудлуудыг тусгах зорилгоор сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сургалтын менежерүүдийг сургах, дэмжих. Сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сургалтын менежерүүдэд зориулан хүнлэг энэрэнгүй, эерэг бөгөөд тусархаг хандлагын талаар сургалт зохион байгуулах. Иргэний боловсролын сургалтын хөтөлбөрт тэгш хамруулах боловсролын агуулгын талаарх суурь ойлголтыг багтаах. Олон талт ялгаатай байдлын талаар эцэг эхчүүдэд чиглэсэн сурталчилгааг дэмжих. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн ялангуяа аавуудын оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих.

Үргэлжлэл дараагийн хуудсанд

Хүснэгт 11: Үргэлжлэл

Дд.	СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ	
		Хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд чиглэсэн	Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн
		<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн бүлгийг сургуулийн дэмжлэгийн багтай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдүүдээ хэрхэн дэмжих талаарх сургалт зохион байгуулах. Үйлдлийн чадварын бэрхшээлгүй хүүхэдтэй эцэг эхчүүдэд чиглэсэн тэгш хамруулах боловсролын ач холбогдлын талаар мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах. Эцэг эхийн зөвлөлтэй хамтран тэгш хамруулах боловсролын талаарх мэдээлэл түгээх арга хэмжээ зохион байгуулах. 	
5	Цэцэрлэг дээр илүү олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хэвшмэл соёлын орчны сөрөг нөлөөлөлд өртдөг.	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн багш нарт бие эрхтэний бэрхшээлтэй (жишээ нь: Хараа, сонсгол, тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй, бусадтай харилцах талаар хүндрэлтэй) хүүхдүүдтэй хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн цэцэрлэгийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлийн талаарх агуулгыг сайжруулах.
6	Найз нөхөдтэй болох, бусадтай харилцах, суралцах зэрэг танин мэдэхүй ба харилцааны ур чадварын хувьд хүндрэлтэй тулгардаг хүүхдүүд хэвшмэл соёлын орчны сөрөг нөлөөлөлд өртдөг.	<ul style="list-style-type: none"> Бусадтай харилцах, өөртөө үйлчлэх, өөрчлөлтөд дасан зохицох, сэргээн санах, найз нөхөдтэй болох, суралцах зэрэгт үйлдлийн чадварын бэрхшээлтэй тулгардаг хүүхдүүдтэй ажиллах талаарх сургалтыг багш нарт зохион байгуулах. 	
7	Сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах явдал тохиолддог.	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүдийн оролцоонд тулгуурласан санаачилгуудыг дэмжих, хүний эрх, нэр хүндийн талаарх ойлголтыг сурагчид, эцэг эхчүүдийн дунд бий болгох сурталчилгааны аян зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> Тэгш хамруулах боловсролын агуулга зэрэг заалтыг ёс зүйн дүрэм, багшийн ажлын байрны тодорхойлолт, сургуулийн ёс зүйн дүрэм зэрэг хууль эрх зүй, бодлогын төрөл бүрийн баримт бичигт нэмж оруулах, эрчимжүүлэх.

Хүснэгт 11: Үргэлжлэл

Дд.	СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ	
		Хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд чиглэсэн	Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн
8	Анги танхимд суралцагчдын тусгай хэрэгцээнд нийцүүлэн ажиллах багш нарын чадавх хангалтгүй.	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээг тодорхойлох арга зүйг сайжруулах, туршлага солилцох, сургалт, арга хэмжээ зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> [Багш бэлтгэх] бүх их, дээд сургуулийн заавал судлах хичээлүүдэд тэгш хамруулах боловсролын талаарх хичээлийг оруулах замаар ирээдүйн багш нарыг бэлтгэх, чадавхжуулах. Багш нарын анги танхим дахь ажлыг дэмжихийн тулд нөөц хөрөнгө хуваарилах (сургалтын хэрэглэгдэхүүн, туслах багш г.м).
Тэгш хамруулсан бодлого боловсруулах			
9	Тэгш хамруулах боловсролын талаарх хууль эрх зүйн баримт бичгүүдийг үе шаттайгаар боловсруулсан боловч мэргэжилтнүүд, багш нар, эцэг эхчүүдийн тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт ялгаатай байна.	<ul style="list-style-type: none"> Сургууль дээр тэгш хамруулах боловсролыг дэмжих тухай хууль эрх зүйн баримт бичгүүдийн талаар мэргэжилтэн, багш, эцэг эх, олон нийтэд сурталчлан мэдээлэх арга хэмжээнүүд зохион байгуулах. Мэдээлэл, сурталчилгааны бүхий л арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг оролцуулах. 	<ul style="list-style-type: none"> Сургуулийн стратеги, жилийн төлөвлөгөөнд хамран сургах тойргийн бүх хүүхдийг тэгш хамран сургах асуудлыг тусгасан бодит индикатор оруулах. Сургуулийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тэгш хамруулах зорилго, индикаторууд болон хэрэгжилтийн үе шатыг оруулж, эдгээрийг хичээлийн жилийн эхэнд багш нар, эцэг эхчүүдэд танилцуулж байх. Багш, удирдах ажилтан, сургалтын менежер болон туслах ажилтнаар ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоог нэмэгдүүлэх.
Тэгш хамруулсан практик үйл ажиллагааг хөгжүүлэх			
10	Цэцэрлэг, сургуулиудын аль аль нь үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд зориулан нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулах, тэдгээрийг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх талаар уян хатан биш.	<ul style="list-style-type: none"> Сургуулийн дэмжлэгийн багийнхны ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх чадавхыг бэхжүүлэх. Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх талаарх багш нарын туршлагыг бусад багш нартай хуваалцах механизм бүрдүүлэх. Зорилтот сургуулиуд дээр хүүхдийн чадварыг үнэлэх, ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөө боловсруулах талаар тусгай сургуулиудаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авах механизмыг бүрдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Ганцаарчилсан хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх талаар нарийвчилсан заавар удирдамжаар хангах. Анги танхим дахь тэгш хамруулсан сургалтыг дэмжих нөөц бололцоогоор хангах (хувийн туслах, туслах багш, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж). Анги танхим дахь үйл ажиллагаанд бүрэн оролцоход нь хүүхдэд шаардагдах тохируулгат хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжтэй байлгах.

Хүснэгт 11: Үргэлжлэл

Дд.	СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ	
		Хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд чиглэсэн	Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн
11	Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа болон агентлаг хоорондын дэмжлэг хангалтгүй.	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд цогц дэмжлэг үзүүлэх тухай сайд нарын буюу ХНХЯ, БСШУСЯ, Эрүүл Мэндийн Яамны хамтарсан тушаал (2018 оны 11 дүгээр сар)-ын хүрээнд Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл болон сургуулийн дэмжлэгийн багуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх санаачилгуудыг сурталчлах, дэмжих. 	<ul style="list-style-type: none"> Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлүүдээр дамжуулан баг, хорооны түвшин дэх сургууль завсардалтын хувийн талаарх мэдээлэл цуглуулах болон Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэх нэг ангилал нэмэх.
Тэгш хамруулсан материаллаг орчныг хөгжүүлэх			
12	Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тулгардаг гадаад орчин дахь хамгийн том саад бэрхшээл нь гэр, сургуулийн хооронд нийтийн тээвэр ашиглахтай холбоотой байна.	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх зэрэг олон нийтийн оролцоонд тулгуурлан нийтийн тээврийн асуудлаар дэмжлэг үзүүлэх багийг турших, ажиллуулах. 	<ul style="list-style-type: none"> Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах, төсөвт суулгах. Нийтийн тээврийн хүртээмж муу газруудад үйлчлэх сургуулийн автобусны тоог нэмэгдүүлэх. Сургууль, цэцэрлэгүүдэд хүрэх авто зам болон явган хүний замыг сайжруулах чиглэлээр орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах.
13	Дотор орчинд хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээл нь ариун цэврийн өрөөний хүртээмжгүй байдал байна.	<ul style="list-style-type: none"> Түгээмэл загварын стандартуудад нийцүүлэн сургууль, цэцэрлэг дээр хөвгүүд, охидын тусдаа бие засах газрын саадгүй нэвтрэх буюу хүртээмжтэй байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих заавар зөвлөмжид ариун цэврийн байгууламжуудыг эрэгтэй, эмэгтэйгээр тусад нь бөгөөд хүртээмжтэй буюу саадгүй нэвтрэх боломжтой байдлаар барих асуудлыг тусгах. Барилгын стандарт, заавруудыг мөрдөн ажиллах явдалд хяналт-шинжилгээ хийх механизмыг баталгаажуулах.

Хүснэгт 11: Үргэлжлэл

Дд.	СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ	
		Хөгжлийн түншүүд болон иргэний нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд чиглэсэн	Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд чиглэсэн
14	Анги танхим дотор тохиолддог үндсэн бэрхшээл нь сургалтын материалууд болон тусгай хэрэгцээнд зориулсан хэрэгслүүдийн тохиромжтой бус байдал юм.	<ul style="list-style-type: none"> • Үйлдлийн чадварын хүндрэл бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багш нарыг арга зүй болон сургалтын материалаар хангах, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар сургах. • Олон талт ялгаатай байдлын талаарх сургалт, ойлголт мэдлэг нэмэгдүүлэх дасгал ажил хийхэд зориулсан хэрэгслүүдээр хангах — жишээлбэл, хүмүүсийн олон талт ялгаатай байдлыг дүрслэн үзүүлсэн цэцэрлэгийн насны хүүхдүүдэд тохирсон тоглоом, хэрэгслүүд, олон талт ялгаатай байдлын талаар өгүүлсэн сургуулиудад зориулсан сургалтын материалууд. 	<ul style="list-style-type: none"> • Тэгш хамруулах боловсролын талаарх журамд олон талт ялгаатай байдлын талаарх сургалт болон ойлголт мэдлэг нэмэгдүүлэх чиглэлээрх ажилд зориулан санал болгосон заах арга зүй, сургалтын тохиромжтой материал, хэрэгслүүдийг хавсралтаар нэмэлт өөрчлөлт болгон оруулах.

БСШУСЯ = Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, ХНХЯ = Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

АХБ. 2017. *Монгол Улс: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулах болон тэдэнд үйлчилгээ үзүүлэх явдлыг баталгаажуулах төсөл*. Манила.

АХБ. 2019а. *Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог хангах нь. Ажиглалт ба саналууд 2019-02*. Манила.

АХБ. 2019б. *Хөгжлийн бэрхшээлтэй хүн Монголд хэрхэн амьдардаг вэ: Тэгш хамралт руу чиглэсэн ахиц дэвшил*. Манила.

АХБ. 2019в. *Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоо: Зардлын хуваарилалт ба үр шим хүртэгчдийн тухай мэдээлэл. Зөвлөхийн тайлан*. Манила (ТТ 8845-МОН).

АХБ. 2020. *Монгол Улс: Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл*. Манила.

Бут, Т., М. Эйнскау. 2002. *Тэгш хамралтын индекс: Сургууль дээрх суралцахуй болон оролцоог хөгжүүлэх нь*. Нэгдсэн Вант Улс: Тэгш хамруулах боловсролын талаарх судалгааны төв.

Кологон, К. 2013. *Боловсрол дахь тэгш хамралт. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын төлөөх тэгш байдал руу*. Асуудал дэвшүүлсэн баримт бичиг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд. Викториа.

Боловсролын комисс. 2017. *Суралцагч үеийнхэн*. Нью Йорк: Боловсролын комисс.

Монгол Улсын Засгийн Газар. 2017. *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллыг дэмжих тухай үндэсний хөтөлбөр, 2018–2022*. Улаанбаатар.

Хараат бус судалгааны хүрээлэн (ХБСХ). 2019. *Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. ТТ 9216-МОН Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын хүртээмж, чанарыг тогтвортой байлгах нь төслийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкнд зориулан бэлтгэсэн техникийн туслалцааны зөвлөхийн тайлан. Манила.

Кулбир Сингх, Р., О. Абу Алгаиб нар. 2019. *Суралцагч нэг бүр үнэ цэнтэй: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгарч буй суралцахуйн хямралыг дэлгэрүүлэн судлах нь*. Вашингтон: Дэлхийн Банкны Бүлэг.

Мэйл, С., К. Водон нар. 2017. *Үл хамруулалтын өртөг: Хөгжлийн бэрхшээл ба боловсрол— Суралцахуйн амжилт болон бичиг үсэг тайлагдалт дахь хөгжлийн бэрхшээлээс үүдсэн зөрүүтэй байдал*. Вашингтон: Боловсролын төлөөх дэлхийн түншлэл, Дэлхийн Банк.

Насан туршийн боловсролын үндэсний төв (НТБҮТ). 2019. *Сургуулийн гадна буй хүүхдүүдийн судалгаа*. НТБҮТ-ийн асуулга судалгааны тайлан. Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ). 2020. *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2018*. Улаанбаатар.

Хүүхдийг Ивээх Сан. 2016. *Тэгш хамруулах боловсрол: Юу, Яагаад, Хэрхэн: Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдэд зориулсан гарын авлага*. Стокгольм.

Хүүхдийг Ивээх Сан. 2018. *Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь төслийн хэрэгцээг тодорхойлох судалгаа*. Улаанбаатар: Хараат бус судалгааны хүрээлэн.

Нэгдсэн Үндэстний Байгууллага. 2016. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо Ерөнхий зөвлөмж 4 (2016) Тэгш хамруулах боловсрол эзэмших эрх. CPRD/C/GC 4. Женев.

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага. 2008. *Тэгш хамруулах боловсрол: Ирээдүйн чиг*. Боловсролын асуудлаарх олон улсын зөвлөгөөний тайлан, 48 дахь удаагийн хуралдаан, 2008 оны 11 дүгээр сарын 25–28. Женев.

НҮБХС. 2016. *Монгол дахь НҮБХС-ийн Улс орны хөтөлбөрийн баримт бичиг 2017–2021*. Улаанбаатар.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС). 2016а. *Хүүхдийн үйлдлийн чадварын модулийн асуулууд*. Нью Йорк.

НҮБХС. 2016б. *Монгол дахь НҮБХС-ийн Улс орны хөтөлбөрийн стратегийн тайлбар*. Улаанбаатар.

НҮБХС, ҮСХ. 2018. *Монгол Улс: Олон үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018*. Улаанбаатар.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Банк. 2011. *Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан*. Малта.

Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцахуйн хямралаас үүдэн ихээхэн хохирол амсаж байна. Тэгш хамруулах боловсролыг дэмжсэн дэлхий дахины үүрэг амлалт нь тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсролыг баталгаажуулах болон бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих тухай Тогтвортой хөгжлийн зорилго 4-т тусгагдсан билээ. Тус баримт бичигт Монгол Улсын ердийн сургуулийн тогтолцооны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэгш хамруулсан боловсролыг олгож байгаа байдлыг 2019 онд 5000 гаруй өрхийг хамруулан хийсэн судалгаа; холбогдох талуудтай хийсэн ярилцлага; болон дөрвөн аймаг, нийслэлийн нэг дүүргийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцсан айлчлал дээр суурилан судалсан. Монгол Улс нь олон улсын түвшний шилдэг туршлагатай нийцүүлэн тэгш хамруулах боловсролын хувьд хууль эрх зүй, бодлогын хүчирхэг орчинг бий болгосон боловч хэрэгжилт болон чадавхын хувьд хангалтгүй байна. Дүгнэлт хэсэгт засгийн газар болон боловсролын салбарын хөгжлийн түншүүдэд зориулсан зөвлөмжүүдийг тусгалаа.

Азийн Хөгжлийн Банкны тухай

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ хүртээмжтэй, тогтвортой, эрсдлийг даван туулах чадвартай хөгжлийг бүс нутагт цогцлоохын төлөө тууштай ажиллаж байна. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 68 гишүүн орны 49 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлж байна.



ASIAN DEVELOPMENT BANK

6 ADB Avenue, Mandaluyong City

1550 Metro Manila, Philippines

www.adb.org